



ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

2025.04.29



АГУУЛГА

Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлын зарлал	03
Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн тогтоол	04
Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлын дэг	06
Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлууд:	
Шийдвэрлэх асуудал:	
1. ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;	07
2. ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;	53
Танилцуулах асуудал:	
1. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан.	58
Шийдвэрлэх асуудал:	
3. ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;	61
4. ХасБанкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:	65
а. Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон өөрчлөн байгуулах;	66
b. Ахмадын сангийн зохицуулалт нэмж тусгах;	71
5. Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;	73
6. ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай.	92
Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл	96
Тооллогын комиссын бүрэлдэхүүн	107
Саналын хуудасны загвар	108

ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАРЛАЛ

ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн R-2025-18 дугаар тогтоолын дагуу Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.4 дэх хэсгийг үндэслэн, хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг үүгээр зарлаж байна.

Компанийн нэр, байршил: ХасБанк ХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72

Хурал болох өдөр, цаг, газар: 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпын гудамж -19 хаягт байрлах Шангри-Ла зочид буудлын Их танхимд хосолсон (танхим болон цахим) хэлбэрээр зохион байгуулагдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах **бүртгэлийн өдөр:** 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан.

Шийдвэрлэх асуудал:

1. ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;
3. ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;
4. ХасБанкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:
 - Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон өөрчлөн байгуулах;
 - Ахмадын сангийн зохицуулалт нэмж тусгах;
5. Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
6. ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай.

Хувьцаа эзэмшигч та хурлын материалуудтай танилцах бол 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн банкны цахим хуудаст (www.xacbank.mn) болон ажлын өдрүүдэд өөрт ойр үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хандах боломжтой.

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч нь өөрийн саналыг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 9:00 цагаас эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 16:00 цаг хүртэл хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан, эсхүл ХасБанкны нийт салбар, тооцооны төвөөр дамжуулан урьчидлан өгөх боломжтой. Саналаа цахимаар өгөхөөр төлөвлөж буй хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурал дуустал хугацаанд өгөх боломжтой.

Холбоо барих:

Утас: +(976)-8508-1888

Цахим шуудангийн хаяг: investor-relations@xacbank.mn

Ажиллах цагийн хуваарь: ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 03 сарын 17, өдөр

№ R-2025-18

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 03 дугаар сарын 13-17-ны өдрийн хооронд зохион байгуулсан цахим санал хураалтаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ТУЗ нь Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("ХЭЭХ")-ыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулах үүрэгтэй ба ТУЗ нь дараах шийдвэрийг батлахыг дэмжсэн болохыг тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны ХЭЭХ-ыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт (Улаанбаатар хотын цагаар) Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж -19 хаягт байрлах Шангри-Ла зочид буудлын Их танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хурлыг танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулсугай.
3. ХЭЭХ-ын даргаар Банкны ТУЗ-ийн дарга Санжай Гүптаг зарласугай.
4. ХЭЭХ-ыг Зохион байгуулах комиссын даргаар Ерөнхий Аудитор Э.Ундармааг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
5. ХЭЭХ-ыг зарлан хуралдуулах тухай мэдэгдлийг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-ид хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.
6. ХЭЭХ-ыг хуралдуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны веб сайт (www.xacbank.mn), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

7. ХЭЭХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байхаар тогтоосугай.
8. ХЭЭХ-аар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, хурлын танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
9. ХЭЭХ-ын хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, ХЭЭХ-ын хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, ХЭЭХ-ын Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, ХЭЭХ-ын дэгийг 4 дүгээр хавсралтаар, ХЭЭХ-ын саналын хуудсыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдэд урьчилсан саналыг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 09:00 цагаас эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 16:00 цаг хүртэлх хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан, эсхүл Банкны нийт салбар, тооцооны төвөөр дамжуулан өгөх боломжийг бүрдүүлэн ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай. Саналаа цахимаар өгөхөөр төлөвлөж буй хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурал дуустал хугацаанд өгөх боломжтой болохыг дурдсугай.
11. Хувьцаа эзэмшигчдээс урьдчилан цаасаар болон цахимаар өгсөн саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал дээр өгсөн саналтай нэгтгэн, тооллогын дүнд оруулан тооцохыг Тооллогын комисст даалгасугай.
12. ХЭЭХ-аас гаргасан шийдвэр болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, мөн холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-нд хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Цаг	№	Үйл ажиллагаа	Хариуцах ажилтан
8:30-9:00	1	Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл	Тооллогын комисс
09:00 цагаас хурал дуусах хүртэл	2	Хурлын ирцийн танилцуулга	Тооллогын комисс
	3	Хурлын үйл ажиллагааны нээлт	Хурлын дарга
	4	Хурлын дэгийн танилцуулга	Гүйцэтгэх захирал
	5	ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	Гүйцэтгэх захирал
	6	Асуулт, хариулт	
	7	ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	Санхүү хариуцсан захирал
	8	Асуулт, хариулт	
	9	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан	ТУЗ-ийн хараат бус гишүүд
	10	Асуулт, хариулт	
	11	ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга	Гүйцэтгэх захирал
	12	Асуулт, хариулт	
	13	ХасБанкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД
	14	Асуулт, хариулт	
	15	Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулга	Гүйцэтгэх захирал
	16	Асуулт, хариулт	
	17	ТУЗ-ийн 2024 оны төсвийн танилцуулга	Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД
	18	Асуулт, хариулт	
	19	Санал хураалтын хаалт	Хурлын дарга
	20	Завсарлага – санал тоолох	Тооллогын комисс
	21	Санал хураалтын нэгдсэн дүнг танилцуулах	Тооллогын комисс
	22	Хурлыг хаах	Хурлын дарга

Санал хураалт/тоолох зарчим: Хувьцаа эзэмшигч нь хэлэлцэх асуудлаар цаасаар болон цахимаар урьдчилан санал өгч болно. Саналыг цаасаар урьдчилан өгөх хугацаа 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 16:00 цагт хаагдана. Саналаа цахимаар өгөхөөр төлөвлөж буй хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурал дуустал хугацаанд өгөх боломжтой. Урьдчилан санал өгөөгүй хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр санал хураах асуудал тус бүрээр дэгт заасан хугацаанд саналаа өгнө.

Хориглох зүйл: Хувьцаа эзэмшигч нь санал хэлэх, асуулт тавих дараалал зөрчих, хэлэлцэх асуудалд хамааралгүй асуудал дэвшүүлэх болон үймээн дэгдээх зэргээр хурлын дэг зөрчихийг хориглоно.



Хурлаар шийдвэрлэх нэгдүгээр асуудал:

ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх
ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай



ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ БАЙДЛААР

Агуулга

- Онцлох үйл явдал
- Санхүүгийн үзүүлэлтүүд
- Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
- Компанийн засаглал



Онцлох үйл явдал



236 сая ам.долларын гэрээ байгуулав

Бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон ногоон бизнесийг дэмжихээр Нидерландын Хөгжлийн Агентлаг (FMO), Азийн Хөгжлийн Банк (ADB), Германы Хөрөнгө Оруулалт, Хөгжлийн Корпораци (DEG), Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD), Франц Улсын Хөгжлийн Санхүүгийн Байгууллага (Proparco), rA, Finnfund, TripleJump, DWM, Symbiotics зэрэг байгууллагуудтай нийт 236.0 сая ам.долларын гэрээ байгуулж үүнээс 176.0 сая ам.долларыг татан төвлөрүүлэв.



Зээлжих зэрэглэл

Олон улсын үнэлгээний Moody's болон Fitch Ratings агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахтай зэрэгцээд ХасБанкны зээлжих зэрэглэлийг мөн "B2 тогтвортой" болон "B+ тогтвортой" болгон тус тус нэг шат ахиулан сайжрууллаа.



Шилдэг төслөөр шалгарлаа

ХасБанкны Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээлийн хөтөлбөр Даян дэлхийн уур амьсгалын түншлэлийн сан (GCPF)-ийн 2024 оны шилдэг төслөөр шалгарч, 10-р сарын 18-ны өдөр Швейцарын Цюрих хотноо болсон ёслолын үеэр шагналыг гардаж авлаа.



Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр


ТУЗ-ийн шийдвэр болон зохицуулагч байгууллагуудаас өгсөн зөвшөөрлийн дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч халааслах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ.

Онцлох үйл явдал

Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ


#Одоо Асуудалгүй

Харилцагчид харилцах дансныхаа мөнгөн хөрөнгийн хэмжээг үл харгалзан тодорхой дүн хүртэл зарлага гаргах эрх олгох үйлчилгээг анх удаа нэвтрүүллээ.




Зорилготой хадгаламж

Зорилгодоо нийцүүлэн хугацаагаа уян хатан тогтоож болох хадгаламжийн шинэ бүтээгдэхүүн дижитал суваг дээр бий болголоо.



Бага дүнтэй гэнэтийн мөнгөний хэрэгцээг богино хугацаанд хялбараар шийдэх АМАР зээлийг шинэчлэн нэвтрүүлэв.



Хэрэглэгч хүссэн бүтээгдэхүүнээ хүүгүй, шимтгэлгүй 4 хуваан худалдан авах боломж бүхий Slice онлайн зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ.



Сторпэй ХХК-тай хамтран “Уртаар” онлайн зээлийн үйлчилгээг нэвтрүүллээ. Ингэснээр хэрэглэгчид хүссэн бүтээгдэхүүнээ урт хугацаатай зээлээр худалдан авахдаа 100% онлайнаар хурдан шуурхай шийдүүлэх боломжийг нээсэн.

ПОС-н орлого барьцаалсан дижитал зээл

ПОС-н орлого барьцаалсан зээлийг 100% дижитал хувилбараар сайжруулан нэвтрүүллээ.




Ханбогд хөгжлийн хурдасгуур Оюу толгой сангийн түншлэл

Өмнөговь аймгийн Ханбогд суманд бизнесийн үйл ажиллагаа явуулж буй болон шинээр бизнес эрхлэх гэж буй иргэн, хуулийн этгээдэд хөнгөлөлттэй нөхцөл бүхий бизнесийн зээл олгох боломжтой боллоо.



Хөтөлбөрийн зээл

ХХААХҮЯам, Батлан даалтын сантай хамтарсан Хоршооны гишүүн малчны зээл, СПАЖЗ Яамтай хамтарсан аялал жуулчлалын салбарыг дэмжих зээлийн хөтөлбөрийг тус тус хэрэгжүүллээ.



Онцлох үйл явдал

| Картын шинэ бүтээгдэхүүн



Тэмүүлэл карт



7-18 насныханд зориулсан Тэмүүлэл карт нийтийн тээвэрт хүүхдийн тарифаар зорчих, дижитал банкаар дансаа удирдах болон бусад хугацаат урамшуулал буцаан олголтод хамрагдах боломжтойгоор шинэчлэгдлээ.



Хасын Хүлэгүүд карт

Сагсан бөмбөгийн Үндэсний дээд лигийн 8 удаагийн аварга Хасын Хүлэгүүд багийн фенүүд, сагсан бөмбөг сонирхогч хэн бүхэнд зориулан Хүлэгүүд картыг цөөн тоогоор гаргалаа.



Future карт

Оюутан залууст зориулан эх дэлхийдээ ээлтэй дахин боловсруулсан пластик материалаар хийгдсэн картыг зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 80 гаруй их дээд сургуулийн 12 мянга гаруй оюутнуудын сонголт боллоо.



Түншлэгч байгууллагуудын карт

Монголын Алт Корпорацийн 30 жилийн ойд, УБТЗ-ын 75 жилийн ойд, Сүү ХК-ийн бэлтгэн нийлүүлэгч малчид, фермерүүдэд зориулсан төлбөрийн картуудыг тус тус гаргалаа.



Олимп карт

Парис 2024 зуны олимпт зориулсан картыг цөөн тоогоор гаргалаа.



Санхүүгийн үр дүн

2024 оны жилийн эцэс

Цэвэр ашиг	ROE	ХАС (хувьцааны ханш)	EPS	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
₮171.7 тэрбум	25.7%	₮826.0	₮163.1	19.2% >12.5%	38.4% >25.0%

Ашигт ажиллагаа

- 2024 оны жилийн эцэст ХасБанкны татварын дараах цэвэр ашиг 171.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 20.9 хувь өслөө. Тайлант хугацаанд Банкны зээлийн багц өссөн болон активын чанарын сайжирсан нь ашгийн хэмжээ нэмэгдэхэд голчлон нөлөөлсөн байна.
- 2024 оны 12 сарын 31-ний байдлаар өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 25.7 хувь, нэгж хувьцаанд ногдох ашиг буюу EPS 163.1 төгрөг байна.
- 2024 онд нийт 61.0 тэрбум төгрөгийн буюу нэгж хувьцаанд 58.0 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ тараалаа. Үүний 15.5 тэрбум төгрөгийг 2023 оны эхний хагас жилийн хуримтлагдсан ашгаас, 26.6 тэрбум төгрөгийг 2023 оны сүүлийн хагас жилийн хуримтлагдсан ашгаас, 18.9 тэрбум төгрөгийг 2024 оны эхний хагас жилийн хуримтлагдсан ашгаас тус тус тараасан байна.

Баланс

- Нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц өмнөх оноос 34.5 хувиар өсөж 3,697 тэрбум төгрөгт хүрлээ.
- Иргэдийн банкны зээлийн багц 34.6 хувиар өсөж 2,587 тэрбум төгрөгт хүрэхэд хэрэглээний болон эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн өсөлт нөлөөлжээ.
- Бэлтгэн нийлүүлэгчидтэй хийсэн хамтын ажиллагаа өргөжсөн, автомашины зээлийн төвүүдийн зэргээс хамааран санхүүгийн түрээсийн багц 36.1 хувиар өсөж 467 тэрбум төгрөгт хүрлээ.
- Байгууллагын банкны зээлийн багц 32.7 хувиар өсөж 643 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нийт харилцах, хадгаламжийн хэмжээ 19.1 хувиар өсөж 3,425 тэрбум төгрөгт, гадаад эх үүсвэрийн хэмжээ 35.8 хувиар өсөж 449 сая ам.долларт тус тус хүрлээ.

Харьцаа үзүүлэлт

- 2024 оны жилийн эцсийн байдлаар Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд бүрэн хангагдаж байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагыг 6.7 нэгж хувиар давуулан биелүүлж 19.2 хувьд хүрлээ.
- 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны үзүүлэлтийг 38.4%-д хангаж, байвал зохих хэмжээнээс давуулан биелүүлэв.
- Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ буурч 2.0 хувь боллоо.

Санхүүгийн үзүүлэлтийн тренд

2024 оны жилийн эцэс

Цэвэр ашиг

Тэрбум төгрөг




Нийт актив

Тэрбум төгрөг



Зээлийн багц

Тэрбум төгрөг



ROE

Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.



1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Зээлийн үйл ажиллагаа

2024 оны жилийн эцэс

Нийт зээлийн тоо

188 мянга ▲ 14.5% YoY

Онлайн зээлийн тоо

112 мянга ▲ 17.5% YoY


Зээлийн хүүгийн орлого

₮575.8 тэрбум ▲ 39.9% YoY

Зээлийн багц

Тэрбум төгрөг


— Чанаргүй зээлийн хувь



Зээлийн багц бизнесийн сегментээр

Тэрбум төгрөг

■ 2023 ■ 2024



- 2024 онд зээлийн багцын өсөлтөд бичил жижиг бизнесийн зээл, хэрэглээний зээл болон санхүүгийн түрээсийн багцын өсөлт голчлон нөлөөлжээ.
- Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол буурч 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2.0 хувьд хүрсэн нь нийт зээлийн багцын өсөлтөөс гадна чанаргүй зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагаа үр дүнтэй байсныг харуулж байна.

Дотоод эх үүсвэр

2024 оны жилийн эцэс

Нийт дансны тоо

1.4 сая ▲ 8.6% YoY

Хадгаламжийн дансны тоо


531 мянга ▲ 5.1% YoY

Харилцагчдад олгосон хүү

₮211.8 тэрбум ▲ 35.6% YoY

Харилцах, хадгаламж


Тэрбум төгрөг



Харилцах, хадгаламж бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг

■ 2023 ■ 2024



- ХасБанк нь харилцагчдын онцлог хэрэгцээ бүрд тохирсон харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог бөгөөд өсөлтөө тогтвортой хадгалж ирсэн.
- Хадгаламж эзэмшигч, харилцагчдад чиглэсэн урамшуулалт хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлснээр 2024 онд нийт харилцах болон хадгаламж 19.1% хувиар өссөн байна.


Гадаад эх үүсвэр

2024 оны жилийн эцэс

2024 онд FMO, ADB, DEG, EBRD, Proparco, rA, Finnfund, TripleJump, DWM, Symbiotics гэсэн байгууллагуудтай нийт 236.0 сая ам.долларын гэрээ байгуулсан бөгөөд үүнээс 176.0 сая ам.долларыг татан төвлөрүүлээд байна. Үлдэгдэл 60.0 сая ам.долларыг 2025 онд татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



Шинэ гадаад эх үүсвэрүүд

FMO environmental development bank \$50,000,000	ADB ASIAN DEVELOPMENT BANK \$50,000,000	KfW DEG \$30,000,000	European Bank for Reconstruction and Development \$25,000,000	PROPARCO ORFÈVRE & P \$25,000,000
responsAbility \$20,750,000	finnfund \$10,000,000	Triple Jump \$10,000,000	dwm \$9,250,000	symbiotics \$6,000,000

Зээлжих зэрэглэл

2024 оны жилийн эцэс

ХасБанк 2008 оноос дэлхийн нэр хүндтэй үнэлгээний агентлагууд болох Moody's Investors Service болон Fitch Ratings байгууллагуудаар өөрийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг тасралтгүй хийлгэж байна. 2024 онд тус 2 үнэлгээний агентлагаас Монгол улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахтай зэрэгцээд ХасБанкны зээлжих зэрэглэлийг "B2 тогтвортой" болон "B+ тогтвортой" болгож нэг шатлалаар тус тус ахиуллаа.

Зээлжих зэрэглэл



Тус үнэлгээний байгууллагууд ХасБанкны үнэлгээг нэг шат ахиулахдаа дараах хүчин зүйлсийг харгалзан үзжээ.*

- **Монгол улсын эдийн засгийн орчны цаашдын хандлага:** Монгол улсын эдийн засаг дунд хугацаанд тогтвортой өсөх хүлээлттэй байгаа бөгөөд энэ нь банкны салбарт эерэгээр нөлөөлөхөөр байна.
- **Өсөлт:** ХасБанк нь зээлийн багцын өндөр өсөлтийг хангахын зэрэгцээ активын чанар болоод өөрийн хөрөнгийн хүрэлцээний хувьд салбарын дунджаас илүү байна.
- **Активын чанар:** 2024 оны хагас жилийн байдлаар чанаргүй зээлийн хувь 2.2 хувь байсан нь салбарын дундаж болох 5.9 хувиас бага байна.
- **Ашигт ажиллагаа:** 2023 оны эцэст цэвэр ашиг 34 хувийн өсөлттэй гарсан бөгөөд цаашид ч мөн адил зээлийн багцын өсөлтөөс хамааран ашигт ажиллагаа сайжрах төлөвтэй байна.
- **Өөрийн хөрөнгийн хүрэлцээ:** Банкны ашигт ажиллагаа хэвийн үргэлжлэх төлөвтэй байгаа нь тус банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ тогтвортой өндөр байх үндэс болж байна.
- **Хөрвөх чадвар:** Гадаадын санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 57 хувиар өссөн бөгөөд энэ нь нийт эх үүсвэрийн 27 хувийг бүрдүүлжээ.

* Эх сурвалж: Fitch Ratings-ийн үнэлгээний тайлан

Хувьцааны мэдээлэл

2024 оны жилийн эцэс

2024 оны 12 дугаар сарын 31-ний буюу оны сүүлчийн арилжааны өдөр ХасБанкны хувьцааны хаалтын ханш 826.0 төгрөгт хүрч өмнөх оны хаалтын ханшаас 31.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд 2023 оны сүүлийн хагас жилийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 25.25 төгрөгийн ногдол ашгийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр, 2024 оны эхний хагас жилийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 18.0 төгрөгийн ногдол ашгийг 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр тус тус хувьцаа эзэмшигчдэдээ тараалаа. 2024 онд тараасан нийт ногдол ашгийн хэмжээ 61.0 тэрбум төгрөг буюу ногдол ашгийн өгөөж 6.9* хувьтай байна.


ХАС хувьцааны ханш, арилжааны хэмжээ



Ногдол ашиг

Тэрбум төгрөг

IPO хийснээс хойш нийт 61.0 тэрбум төгрөгийн ногдол ашиг



* Ногдол ашгийн өгөөжийг тухайн онд тараасан нэгж хувьцааны ногдол ашгийг 2023 оны хаалтын ханшинд харьцуулж тооцов.

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


2024 оны жилийн эцэс

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн
зохистой харьцаа

19.2% Байвал зохих доод хэмжээ 12.5%


Төлбөр түргэн гүйцэтгэх
чадварын харьцаа

38.4% Байвал зохих доод хэмжээ 25.0%



Түргэн борлогдох актив

Нийт 2,034.2 тэрбум төгрөг



Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	2022	2023	2024
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	6.2%	-1.3%	-1.7%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	6.9%	-1.4%	-2.0%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	66.6%	38.6%	41.7%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	1.7%	1.3%	1.2%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	7.7%	7.8%	7.9%

	2022	2023	2024
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):			
Банкны хувьцаа эзэмшигчид	0.0%	0.8%	2.2%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	1.6%	3.2%	0.0%
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):			
Банкны хувьцаа эзэмшигчид	0.0%	0.8%	2.3%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.3%	0.3%	0.3%
Банкны бусад холбогдох этгээд	3.8%	3.2%	0.1%

Сангаас хаасан зээлийн мэдээлэл

2024 оны жилийн эцэс

Сангаас хаасан зээл, бүтээгдэхүүнээр

Бүтээгдэхүүн	Сангаас хаасан зээлийн хэмжээ (Сая төгрөгөөр)	Зээлийн тоо
Бичил, жижиг, дунд бизнесийн зээл	151	9
Орон сууцны зээл	223	2
Хэрэглээний зээл	1,370	169
Тээврийн хэрэгслийн зээл	18	3
Нийт	1,761	183

Тэмдэглэл

- 2024 оны 11 дүгээр сарын Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар сангаас хаах зээлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэсэн;
- Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан тушаалаар баталсан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын шаардлагыг бүрэн хангасан зээлүүдийг сангаас хаасан;
- Банк нь зээлийг сангаас хааснаар өр төлүүлэх ажиллагааг зогсоохгүйгээр үргэлжлүүлдэг;
- Тиймээс сангаас хаасан зээлийг төлүүлэхтэй холбоотой шүүхийн журмаар төлбөр барагдуулах ажиллагааг үргэлжлүүлж байна.

ХасБанк ХК-ийн Засаглалын тайлан

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан

1. ЗАСАГЛАЛЫН ТОЙМ
2. ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО
3. ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО
4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БА НЭГТГЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ
5. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ
6. НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ
7. ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ХӨТӨЛБӨР
8. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
9. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД
10. ЁС ЗҮЙН КОДЕКС, СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ БА ТОЛИЛУУЛГА
11. КОМПАНИЙН БҮТЭЦ
12. УДИРДЛАГЫН БАГ

1. ЗАСАГЛАЛЫН ТОЙМ

ХасБанк нь өнгөрсөн жилийн хугацаанд сайн засаглалыг бэхжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хувьсан өөрчлөгдөж буй зохицуулалтын орчинд нийцэн ажиллах зорилтын хүрээнд багагүй ажлыг хийж гүйцэтгэлээ. Эдгээрээс чухалчлан дурьдвал, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгож, 2 шинэ гишүүнээр эгнээгээ тэлсэн, Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журмыг баталсан, Банкны тухай хуулийн 36.1-д заасан аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт банкны нийт гаргасан хувьцааны 20%-аас дээш эзэмшихгүй байх шаардлагыг хангах үүднээс ХасБанкийг түүний толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-тай нэгтгэх шийдвэрийг хувьцаа эзэмшигчид хэлэлцэж баталсан зэрэг үйл явдлуудыг дурьдаж болно.



ХасБанкны хувьцаа эзэмшигчид 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр ээлжит хурлаараа ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанк ХК-д нэгтгэж, ХасБанк ХК-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх замаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийг ХасБанкны шууд хувьцаа эзэмшигч болгох замаар Банкны тухай хуулийн 36.1-д заасан шаардлагыг биелүүлэх шийдвэр гаргав. Монголбанк уг шийдвэртэй холбоотой нэгтгэх хүсэлтийг хянаж байна.



2024-2026 оны хооронд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгож, 12 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ТУЗ-өө байгууллаа. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр 2 гишүүн нэмэгдсэнээс нэг нь хараат бус гишүүн, нөгөө нь энгийн гишүүн байна.



ТУЗ нь 2024 онд дотоод засаглалын орчныг сайжруулах зорилгоор тодорхой журмуудыг шинэчлэн сайжруулсан байна. Мөн түүнчлэн, шинээр “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам”-ыг баталсан. Уг журмаар банкны урт хугацааны үнэ цэнийг бий болгоход удирдлагын тогтвортой үйл ажиллагаагаар дамжуулан гадаад болон дотоод оролцогч талуудтай үр дүнтэйгээр харилцаж, хамтран ажиллахад баримтлах тодорхой чиглэл, удирдамжийг тогтоож байна.

ТУЗ-өөс баталсан бодлого, журам	
Шинэчлэн баталсан, нэмэлт өөрчлөлт оруулсан	Шинээр баталсан
- Төлөөлөн удирдах зөвлөлийн (үнэлгээний дараах) 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээний журам - ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын Хорооны дүрэм - Дотоод аудитын дүрэм - ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам	- Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам - Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлдэх бодлого

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос баталсан Компанийн засаглалын кодекс-ийн удирдамжийн үнэлгээний аргачлалын дагуу ХасБанкны “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт”-ийн 2024 оны тайланг СЗХ-ноос хянан баталгаажуулж **93.1%** буюу **засаглал сайн, эрсдэлгүй** гэж үнэлсэн.

Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай Монголын хөрөнгийн бирж ХК болон компанийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

№	Гарчиг	Авбал зохих оноо	2023.06.30-ны байдлаар		2024.12.31-ний байдлаар		Өөрчлөлт хувь
			СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	9	75%	10	83.3%	8.3%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7	70%	7	70%	-
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100%	6	100%	-
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%	6	100%	-
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%	-
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	6	100%	-
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%	-
8	Компанийн соёл	6	6	100%	6	100%	-
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%	10	100%	-
Нэгдсэн дүн		72	66	91.7%	67	93.1%	+1.4%

2. ХАСБАНКНЫ ЗАСАГЛАЛ

ХасБанк нь өөрийн Засаглалын Кодекс (2023)-ийн дагуу ХасБанкны засаглалын тогтолцоог **хувь нийлүүлсэн хөрөнгийн үнэ цэнийг урт хугацаанд нэмэгдүүлэх зорилго бүхий, Банкны хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага хоорондын удирдлага, хяналтын цогц бүтэц болон үйл ажиллагаа** гэж тодорхойлдог.

Банкны засаглал нь дараах зарчимд үндэслэнэ:



Банкны засаглалын бүтэц:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хувьцаа эзэмшигчдэд банкны засаглалд оролцох боломжийг олгодог банкны эрх барих дээд байгууллага байна.
- ХасБанкны ТУЗ нь Банкны үндсэн үйл ажиллагааг стратегийн удирдлага, өргөн хүрээний хяналтаар хангах үндсэн чиг үүрэгтэй. ТУЗ нь аудитын, эрсдэлийн удирдлагын болон засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороотой.
- Гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын баг нь Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, стратегийг хэрэгжүүлж ажиллана.

3. ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Дотоод аудитын тогтолцоо

ХасБанкны Дотоод Аудитын газар нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд шууд тайлагнадаг. Дотоод аудитын газар нь бүтцийн хувьд Газар дээрх Аудитын хэлтэс болон Зайны Аудитын хэлтэс гэсэн бүтэцтэйгээр нийт 17 аудитортай ажиллаж байна.

Дотоод аудитын зорилго нь хараат бус, эрсдэлд суурилсан, бодитой баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээг үзүүлэх замаар банкны үнэ цэнийг өсгөх, хамгаалах, тогтвортой байлгах чадварыг бэхжүүлэхэд оршдог бөгөөд энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд банкны засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлж, үйл ажиллагааг сайжруулах, хяналт, үр ашгийг дээшлүүлэх зөвлөмжийг боловсруулан аудитлуулагч талд бэлтгэн хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих байдлаар ажилладаг.

2024 онд аудитын бодлогын баримт бичгүүдийг олон улсын стандартын өөрчлөлтийн дагуу шинэчлэн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд танилцуулан батлуулсан бөгөөд аудитын үйл ажиллагаанд хувьсан өөрчлөгдөж буй бизнесийн нөхцөл байдалтай уялдуулан арга аргачлал сайжруулалтыг нэвтрүүллээ.

Дотоод аудитуудын олон улсын институтийн Монгол дахь албан ёсны салбар байгууллагаас ХасБанкны Дотоодын Аудитын нэгжийг 2024 оны шилдэг нэгжээр шалгаруулан батламж олгосон.



Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

ХасБанкны эрсдэлийн удирдлагын зорилго нь эрсдэлийн удирдлагын засаглалыг тогтмол сайжруулж, эрсдэлийг удирдах аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, эрсдэлийн удирдлагын бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг Банкны бизнесийн стратегитай нийцүүлснээр Хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг урт хугацаанд нэмэгдүүлэхэд оршдог.

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийн цар хүрээ, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээ буюу эрсдэлийн аппетит, хамгаалалтын гурван бүс, стресс тест, хяналт, тайлагналтаас бүрддэг. Банкны эрсдэлийн удирдлагын дотоод хяналт нь хамгаалалтын гурван бүсийн зарчимд суурилсан бөгөөд тэдгээрийн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлон үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:



Хамгаалалтын нэгдүгээр бүс нь эрсдэлийг хариуцах эзэн нь байх бөгөөд өөрийн үйл ажиллагаа дахь өдөр тутмын эрсдэлийг удирдана;



Хамгаалалтын хоёрдугаар бүс нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого, журмыг боловсруулан батлуулж, тэдгээрийн хэрэгжилт, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээ, хязгаар үзүүлэлтүүдэд хяналт тавьж ажиллана. Мөн хамгаалалтын нэгдүгээр бүсийн хяналтын үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна тэдгээрийн үйл ажиллагаанд байнгын дэмжлэг үзүүлж ажиллана;



Хамгаалалтын гуравдугаар бүс нь эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлж, хамгаалалтын нэг, хоёрдугаар бүсийн эрсдэлийг үр дүнтэй удирдаж буй байдалд хараат бүс үнэлгээг хийж, дүгнэн ажиллана.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлийн багц нь Банкны активын үндсэн хэсгийг бүрдүүлдэг тул зээл, зээлийн эрсдэл нь Банкны удирдах шаардлагатай томоохон эрсдэлийн нэг юм. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсны улмаас зээлийн эрсдэл үүсдэг. Үүнээс гадна зээлийн хэт их төвлөрөл нь зээлийн төвлөрлийн эрсдэлийг үүсгэдэг.

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь зээл, зээлийн багцын төвлөрөлтэй холбоотой хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг хэлэлцэн, баталдаг. Энэхүү хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг хэрэгжүүлэхийн тулд Банкны зээлийн эрсдэлийг удирдах журамд зааснаар зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн хувьд эрсдэлийн хязгаар нөхцөлийг тодорхойлон, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай тохиолдолд шинэчилж, зээлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Түүнчлэн, Банкны тухай хууль, тогтоомжид заасан зээлийн төвлөрөлтэй холбоотой хязгаар нөхцөлүүдийг хангаж ажиллахаас гадна эдийн засгийн сектор, зээлийн бүтээгдэхүүний хувьд мөрдөх эрсдэлийн лимитийг тогтоон, хяналт тавьж, холбогдох тайланг зохицуулагч байгууллага болон Банкны удирдлагуудад тайлагнан ажиллаж байна.

Үйл ажиллагааны эрсдэл

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын бичиг баримтад үйл ажиллагааны эрсдэлтэй холбоотой хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг хэлэлцэн, баталдаг. Үйл ажиллагааны эрсдэлийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг хэрэгжүүлэхдээ Банк нь үйл ажиллагааны эрсдэлийг удирдах журмыг батлан мөрдөж байна. Банкны газар, нэгжүүд нь тус тусын үйл ажиллагаа дахь эрсдэлийн үнэлгээг хийж хэвшсэн бөгөөд тухай бүр эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж ирлээ. Үүний үр дүнд хүний хүчин зүйл, дотоод процесс, мэдээлэл технологийн алдаа доголдлоос үүсэх аливаа үйл ажиллагааны эрсдэлийг удирдаж, давтагдан гарахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны эрсдэл хариуцсан нэгж нь үйл ажиллагааны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, тайлагнах

зэрэг эрсдэлийн удирдлагын тогтолцооны талаарх мэдлэг олгох сургалтаар дамжуулан Банканд эрсдэлийн соёлыг бий болгон ажилладаг.

Нийгэм, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн удирдлага

Нийгэм, байгаль орчны эрсдэл, уур амьсгалын өөрчлөлт нь Банкны үйл ажиллагаанд тодорхой хэмжээний эрсдэлийг бий болгоно гэдгийг ХасБанк хүлээн зөвшөөрч, эрсдэлийн цар хүрээ, эрсдэлийн төрөлдөө уур амьсгалын өөрчлөлтийн биет болон шилжилтийн эрсдэлийг тодорхойлсон бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн шилжилтийн төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлуулан ажиллаж байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зээлийн багцын материаллаг байдлын үнэлгээг хийснээс гадна Банкны өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хий, Банкны санхүүжүүлсэн хүлэмжийн хийн хэмжээг тооцож эхлээд байна. Цаашид Монгол Улсын Парисийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтод нийцүүлэн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тодорхойлохоор ажиллаж байна.

Комплаенс

Банкны комплаенсийн функцийн зорилго нь тогтвортой бизнесийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор Банкны Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, дотоод болон гадаад түншлэлээр дамжуулан Банк, харилцагчид болон олон нийтийн харилцаанд эерэг үр дүнд хүрэхэд оршино. Мөн түүнчлэн, Банкны нэр хүндийг хамгаалах, ёс зүйн стандарт болон хууль эрх зүйн үүргээ биелүүлэхийн тулд дотоод хяналтын арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Комплаенсийн эрсдэл нь санхүүгийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлага, тухайн салбарын бизнесийн болон мэргэжлийн ёс зүйн стандартыг дагаж мөрдөөгүйгээс Банк нь бизнесийн үйл ажиллагааг амжилттай явуулах боломжгүй болох эрсдэлийг хэлдэг. Үүнд, ялангуяа санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, залилан болон авлига, хээл хахуультай тэмцэх зохицуулалтууд орно.

ХасБанк нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС)-тэй тэмцэх үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор харилцагчийн эрсдэлийн үнэлгээ, бодит цагийн горимоор ажиллах гадаад гүйлгээний хяналт, дүрмийн дагуу гүйлгээний хяналт болон тайлан зэргийг хамруулсан цогц программыг 2023 онд амжилттай нэвтрүүлсэн ба 2024 онд программын ажиллагааг комплаенсийн нэгжийн хяналтын үйл ажиллагаатай илүү уялдуулан хөгжүүлж, зохих хяналтуудыг оновчтой хийж ажилласан. Системийн шинэчлэл сайжруулалтаас гадна бид ажилтнуудад санхүүгийн гэмт хэрэг, МУТС болон ёс зүйн хэм хэмжээний талаар тогтмол мэдлэг олгох арга хэмжээ болон сургалтууд зохион байгуулан ажиллаа.

2024 онд Комплаенсийн хэлтсээс Комплаенсийн газар болон өргөжиж үйл ажиллагаанд ашиглагддаг программ хангамж, хянан нийцүүлэлтийг хангахад чиглэсэн дотоод бодлого журмын уялдаа жил ирэх тусам туршлага, мэдлэгт тулгуурлан сайжирч байгаа нь банк болоод харилцагчийг болзошгүй санхүүгийн гэмт хэрэгт өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд том дэмжлэг болж байна.

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БА НЭГТГЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ

ХасБанк нь банкны системд нөлөө бүхий банк болохын хувьд Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлага болох аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт банкны нийт гаргасан хувьцааны 20-иос дээш хувиар эзэмшихгүй байх шаардлагыг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор хангах ёстой.

Бидний хувьд уг шаардлагыг эцсийн өмчлөгчийн түвшинд хангаж байна. ХасБанкны 94.99% хувийг эзэмшиж буй ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоод болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд болон хувь хүмүүсээс бүрдсэн нийт 10 хувьцаа эзэмшигчидтэй.



Харин шууд өмчлөгчийн түвшинд хангах зорилгоор ХасБанкинд түүний толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийг нэгтгэхээр 2024 онд ХасБанкны хувьцаа эзэмшигчид шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийг биелүүлж, нэгтгэх үйл ажиллагааг дуусгахаар холбогдох ажлууд хийгдэж байгаа бөгөөд холбогдох хүсэлтүүдийг хянан шийдвэрлэх ажиллагаа Монголбанкинд үргэлжилж байна.

5. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн, Банкны нийт гаргасан хувьцааны ердийн олонх буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар:

- Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг
- Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг
- ХасБанкны дүрмийн 8.6 дахь хэсэгт заасан асуудлуудыг тус тус хэлэлцэж, шийдвэрлэдэг.

ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах өдрүүдэд зохион байгуулагдав.

Хурлын огноо	Ээлжит/ ээлжит бус	Санал хураалтын хэлбэр	Хурлын ирц
2024.02.02	Ээлжит бус	Эчнээ	96.51%
2024.04.29	Ээлжит	Танхим болон цахим хосолсон	95.88%
2024.07.25-09.04	Ээлжит бус	Эчнээ	95.64%

Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон шийдвэрүүдтэй ХасБанкны цахим хуудасны Хөрөнгө оруулагч цэсийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хэсгээс танилцана уу.

6. НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

ХасБанк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон зохицуулагч байгууллагаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, ирээдүйн бизнесийн тэлэлтийн боломж, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын цаашдын чиг хандлага зэргийг харгалзан үзэж хуримтлагдсан ашгаас **ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг жилд 2 удаа хэлэлцэн, шийдвэр** гаргадаг.

Энэхүү ногдол ашгийн бодлогын хүрээнд ХасБанк нь 2024 онд хуваарилсан ногдол ашгийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

Ногдол ашиг	Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүн /төгрөг/	Шийдвэрийн огноо	Хувьцаа эзэмшигчийн нэрийн дансанд байршуулж дууссан огноо
2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хуваарилсан ногдол ашиг	25.25	2024.04.29	2024.04.30
2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас хуваарилсан ногдол ашиг	18.00	2024.09.04	2024.09.10
2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хуваарилахаар хүлээгдэж* буй ногдол ашиг	27.00	-	-

*ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн R-2025-03 тоот тогтоолоор Банкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 27.00 (хорин долоо) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд жилийн эцсийн ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд тус шийдвэрийг Монголбанкнаас зөвшөөрч, Банкны Дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсны дараагаар ногдол ашгийг хуваарилахаар хүлээгдэж байна.

7. ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ХӨТӨЛБӨР

ХасБанк өөрийн жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 2 дугаар хагасаас хойш 2024 оныг дуустал хугацаанд хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг 2 удаагийн шийдвэрээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хүрээ хязгаарлагдмал, хувьцааны хөрвөх чадвар сул байгаа өнөөгийн нөхцөлд жижиг хувьцаа эзэмшигчид нь хүссэн үедээ цал алдахгүйгээр өөрийн эзэмшиж буй хувьцаагаа мөнгөжүүлэхэд хүндрэлтэй байдаг. Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр нь нээлттэй, ил тод байдлаар, зохицуулагч байгууллагын зөвшөөрөлтэйгээр хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлж жижиг хувьцаа эзэмшигчдэд учирч буй хүндрэлийг бууруулах зорилготой.

Уг хөтөлбөр нь банкны өөрийн хөрөнгийг бууруулахад чиглээгүй бөгөөд зөвхөн жижиг хувьцаа эзэмшигчдэд туслах зорилготой болно. Иймд, Банк нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаагаа өндөр түвшинд хадгалах бодлогоо тогтвортой хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХасБанк нь нийт гаргасан хувьцаа болох 1,052,700,000 ширхэг хувьцааны 0.03% болох 296,678 ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслаад байна. Энэхүү халаасалсан хувьцааг Компанийн тухай хуулийн дагуу эргэлтэнд гаргах тохиолдолд холбогдох зохицуулагч байгууллагын зөвшөөрөлд үндэслэн Хувьцаа эзэмшигчдээр шийдвэрлүүлэх болно.

8. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ТУЗ нь Банкны дүрмийн дагуу 12 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. ТУЗ нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 12 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж буйгаас ТУЗ-ийн дарга 1, Гүйцэтгэх удирдлагын төлөөлөл болох 1 гишүүн, Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 6 гишүүн болон хараат бус 4 гишүүний бүрэлдэхүүнтэй.



Санжай Гүпта

ТУЗ-ийн дарга

Мэргэшсэн чиглэл:

Эдийн засаг, санхүү

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

43 жил

Боловсрол:

Дели дэх Сэинт Стивинг коллеж, Физикийн шинжлэх ухааны бакалавр, Дели Их Сургуулийн Менежментийн факультет, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

1981-2001	БНЭУ, Англи болон ХонгКонг дахь Банк оф Америка. Төрөл бүрийн албан тушаал: Байгууллагын банк хариуцсан захирал, Энэтхэг дэх Файнэншл Инститюшнс Групп хариуцсан захирал, Европ, Ойрх Дорнод, Африкийн (ЕОДА) Эрсдэлийн удирдлага хариуцсан захирал, ЕОДА-ийн Стракчард Кредит Группийн гүйцэтгэх захирал, Ази дахь Инвестмент Банкинг Группийн Гүйцэтгэх захирал
2001-2005	Кредит Лионассд Ази, Номхон далайн бүсийн Байгууллагын Зээл хариуцсан захирал
2006-2015	Кредит Агриколь Групп, Зээлийн дахин санхүүжилт хариуцсан захирал, Глобал Энержи Группийн Ази хариуцсан захирал
2017-2019	ТСН, ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2019 оноос	ТСН, ХасБанкны ТУЗ-ийн дарга

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

850,541 ширхэг (0.08%)



ЭМИ ЧОЙ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл:

Мэдээллийн системийн шинжилгээ, бизнесийн шинжилгээ

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

40 жил

Боловсрол:

Хонконгийн Политехникийн их сургууль, Мэдээллийн системийн шинжилгээ, дизайны чиглэлээр диплом, Лондонгийн Сити их сургууль Бизнесийн шинжилгээ, дизайны чиглэлээр шинжлэх ухааны магистр

Ажлын туршлага:

1982-1993	Хонконг дахь АйБиЭм, Систем инженер, банк, даатгалын салбарын системийн автоматжуулалт чиглэлээр ажиллаж байсан. Кредит Лионассд Ази, Номхон далайн бүсийн Байгууллагын Зээл хариуцсан захирал
1994-2010	Төрөл бүрийн албан тушаал: Салбарын менежер, Олон улсын хувийн банк хариуцсан албаны захирал, Ерөнхий захирал ТСН, ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2010-2013	Иргэдийн банк хариуцсан гүйцэтгэх дэд ерөнхийлөгч, Хятадын Гуангфа Банк
2013-2017	Иргэдийн банк хариуцсан дэд ерөнхийлөгч, Пинг Ань Банк
2017-2020	Гүйцэтгэх захирлын орлогч, Зүүн Азийн Банк
2023 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Хувьцаа эзэмшдэггүй.



НИРАЖ ВЭДВА

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл:

Мэдээллийн технологи, худалдаа, бизнес

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

30 жил

Боловсрол:

Дели их сургууль бакалавр, Индира Гандигийн нэрэмжит их сургууль, Худалдаа, маркетингийн чиглэлээр магистр

Ажлын туршлага:

1987-1994	Нэтворк Лимитед компани, Дүүргийн худалдааны менежер
1994-1997	ТиЭнТи Экспресс, Хойд Энэтхэг, Балба бүсийн худалдааны менежер
1997-1999	Модикорп компани, Дотоод худалдааны менежер,
1999-2011	Нуклеус Софтвэр, Үйл ажиллагаа хариуцсан захирал
2011-2013	Швейцар Улсын Темонос компани, Ази, Номхон Далайн Бүсийн захирал
2013	Тек Махиндра, Олон улс хариуцсан менежер
2018 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр
2019 оноос	Акселерик Эф Зи компанийн Үүсгэн байгуулагч/ Гүйцэтгэх захирал

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Хувьцаа эзэмшдэггүй.

**СТЮАРТ ХОЛЛ****ТУЗ-ийн хараат бус гишүүн**

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл:

Санхүү, Нягтлан бодох

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

41 жил

Боловсрол:

Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльсийн Их Сургууль, Худалдааны бакалавр, Мэргэшсэн нягтлан бодогч

Ажлын туршлага:

1886-1994	Американ Экспресс Банк, захирал
1994-2005	Стандарт Чартеред Банкны Индонез, Лондон дахь салбар, Төрөл бүрийн албан тушаал, Захирал
2005-2009	Индонез Улсын Пермата банкны Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгч
2009-2011	Стандарт Чартеред Банкны Индонез, Сингапур, Филиппин дэх банк, Захирал
2011-2013	Азийн Худалдааны Банкны ТУЗ-ийн гишүүн, Вьетнам ХасБанкны хувьцаа эзэмшлийн хэмжээ
2013-2017	ДиЖейЭм Капитал ХХК дарга,

2018
2024 оноос

Индонез Улсын Пермата банкны Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгч
ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Хувьцаа эзэмшдэггүй.



БАЯНСАНЫ УЛАМБАЯР

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны гишүүн

Мэргэшсэн чиглэл:

Бизнесийн удирдлага

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

18 жил

Боловсрол:

Токиогийн технологийн их сургууль, Электроникийн инженерийн бакалавр, болон магистр, мөн АНУ-ын Чикагогийн Их Сургуулийн Бизнесийн сургуульд бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

2001-2005	Сони Корпораци, инженер
2007-2009	Лиман Бродерс/Номура Секьюритис, хөрөнгө оруулалтын банкир
2009-2011	Алдай Холдинг ХХК, дэд захирал гүйцэтгэх захирал
2011-2012	Композит Капитал, гүйцэтгэх захирал,
2013	Говь Бизнес Финанс ХХК, хамтран үүсгэн байгуулагч, зөвлөх
2014-2016	Дрэйпер Капитал, ахлах зөвлөх
2015 оноос	ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Хувьцаа эзэмшдэггүй.



ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ

ТУЗ-ийн гишүүн бөгөөд Гүйцэтгэх захирал

Мэргэшсэн чиглэл:

Банк, санхүү

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

20 жил

Боловсрол:

АНУ-ын Колорадогийн Их Сургууль, Бакалавр, Рэжис Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

2004-2008	АНУ-ын Дэнвер хотод байрлах Wagner Equipment, хөрөнгө зохицуулалтын шинжээч, олон улсын нягтлан бодогч
2008-2010	Сан Франциско хотод байрладаг Рэсторэшэйн Хардвэйр компани, хөрөнгө зохицуулалтын менежер, Bluefin Associates (PlumSlice) компанид санхүү эрхэлсэн захирал
2011-2019	ХасБанк, Төрөл бүрийн албан тушаал: Ерөнхий захирал, Иргэдийн банк хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, ХасЛизинг ХХК-д Гүйцэтгэх захирал, Тэнгэр Даатгал ХХК-д Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д Санхүү хариуцсан захирал,
2019 оноос	ТСН, ХасБанкны Гүйцэтгэх захирал болон ХасБанкны ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

1,887,582 ширхэг (0.18%)



АЛБЕРТУС БРАГГИНК

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, Орикс группийн төлөөлөл

Мэргэшсэн чиглэл:

Санхүү

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

38 жил

Боловсрол:

Нидерландын Твенте их сургуулийн Бизнесийн удирдлагын магистр болон доктор

Ажлын туршлага:

1986- 2016	Нидерландын Рабо банк, Төрөл бүрийн албан тушаал: Санхүү, Эрсдэл хариуцсан захирал, Санхүү, хяналт шалгалтын захирал,
2016 оноос	ОРИКС Корпорацийн ТУЗ-ийн зөвлөх,
2021 оноос	ТСН, ХасБанкны ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Хувьцаа эзэмшдэггүй.



АНДЖЕЙ ВИТАК

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, ЕСБХБ-ны төлөөлөл

Мэргэшсэн чиглэл:

Банк, санхүү

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

39 жил

Боловсрол:

Польш улсын Силезиа их сургууль, Хууль зүйн магистр

Ажлын туршлага:

1983-1984	TWD, Экспорт-импортын мэргэжилтэн
1985-1987	Fosco, Санхүү хариуцсан захирал
1987-1990	Corect, Бие даасан зөвлөх
1990-1991	Gliwicki bank handlowy sa, дэд ерөнхийлөгч
1992-1997	Польшийн Хандлово Банк, Польшийн Төв банкнаас томилогдсон эрх хүлээн авагч, менежир
1997-2007	Европын сэргээн босголт, хөгжлийн банк, ахлах банкир, Украин Улс хариуцсан Дэд захирал
2007 оноос	Бие даасан зөвлөх
2019 оноос	TCH, ХасБанкны ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Хувьцаа эзэмшдэггүй.



МАЙКЛ МАДДЕН

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга, Ронкок Партнерз Кэй Эф Ти компанийн төлөөлөл

Мэргэшсэн чиглэл:

Санхүү, хөрөнгө оруулалт

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

31 жил

Боловсрол:

Ирланд улс, Менежментийн коллеж, Дээд, Компанийн засаглалын хөгжлийн төв, Мэргэжлийн сургалт

Ажлын туршлага:

1993-2003	Американ Экспресс санхүүгийн байгууллагын ОХУ болон Ирланд дахь салбарт хэд хэдэн албан тушаал
2003-2007	Банк Ренесанс Кредит, үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал

2007 оноос	Ронок компани, Үүсгэн байгуулагч, Партнер
2009 оноос	ТСН, ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2015 оноос	Ронок Азиа ПиТиИ компани, Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга
2024 оноос	Конселло Групп, Партнер

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Шууд хувьцаа эзэмшдэггүй.



НЯМТАЙШИР ЦЭЛМҮҮН

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн, МАК Инвест Кэй Эф Ти компанийн төлөөлөл

Мэргэшсэн чиглэл:

Хөрөнгө оруулалт, бизнес

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

19 жил

Боловсрол:

АНУ-ын Индиана мужийн Вальпараисо Их сургууль, Бизнесийн удирдлага, бакалавр, санхүүгийн инженерингийн чиглэлээр Стэнфордын Их Сургуулийн Хонгконг гэрчилгээт сургалт, Харвардын их сургууль, Бизнесийн сургууль, Удирдлагын хөгжил хөтөлбөр

Ажлын туршлага:

2005-2007	Худалдаа хөгжлийн банк, Менежер
2007-2010	Монголын Алт ("МАК") ХХК, Ахлах мэргэжилтэн
2010-2012	Монголын Алт ("МАК") ХХК, Худалдаа болон хөрөнгө оруулалт, санхүүжилтийн газрын захирал
2012-2016	Монголын Алт ("МАК") ХХК, Худалдаа, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд ерөнхийлөгч, Бодлогын зөвлөлийн гишүүн
2013 оноос	ТСН, ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
2016 оноос	Монголын Алт ("МАК") ХХК, Ерөнхийлөгч/ Гүйцэтгэх захирал

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Шууд хувьцаа эзэмшдэггүй.



СЮЗАННА ХЕРРИНГ КАРР

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн, Олон Улсын Санхүүгийн Корпорацийн төлөөлөл

Мэргэшсэн чиглэл:

Хөрөнгө оруулалт, санхүү

Ажлын туршлага:

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:	
37 жил	
Боловсрол:	
АНУ, Дьюкийн их сургууль, Эдийн засгийн бакалавр	
1987-1993	Фёрст Фиделити Банк Корпорейшн/СМС Компани, банкир
1994-1995	Солидарити Үйлдвэрчний Эвлэл/Энх тайвны Корпус, Бизнесийн зөвлөх,
1996-2019	Дэлхийн Банкны Группын гишүүн Олон Улсын Санхүүгийн корпораци, Төрөл бүрийн албан тушаал: Хөрөнгө оруулалтын мэргэжилтнээс Ахлах зөвлөх хүртэл
2021-2022	Дэлхийн Банкны Хараат бус үнэлгээний группын зөвлөх
2022 оноос	ТСН, ХасБанкны ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Хувьцаа эзэмшдэггүй.



ДОМИНИК ЖАК

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Канадын үндэсний банкны төлөөлөл

Мэргэшсэн чиглэл:

Банк, санхүү, аудит

Санхүүгийн зах зээлд тасралтгүй ажилласан туршлага:

23 жил

Боловсрол:

Монреалийн Их Сургууль, Бизнесийн удирдлагын бакалавр, Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр ахисан түвшний диплом, мэргэшсэн нягтлан бодогч (CPA) болон мэргэшсэн санхүүгийн шинжээч (CFA).

Ажлын туршлага:

2001-2009	Прайс УатерХаус Күүперс компани, Ахлах шинжээч, менежер, ахлах менежер
2010 оноос	Канадын Үндэсний Банк, одоогийн албан тушаал Олон улсын асуудлыг хариуцсан Дэд ерөнхийлөгч
2024 оноос	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн

Эзэмшиж буй ХасБанкны хувьцаа

Шууд хувьцаа эзэмшдэггүй.



ХасБанк нь “ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журам”-ыг 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус журамд заасны дагуу ТУЗ нь хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудаас гадна ХасБанкны эрх ашгийг бүхэлд нь хамгаалж чадахуйц, аливаа зүйлийг өргөн хүрээнд авч үздэг, ур чадвартай, үр дүнтэй шийдвэр гаргах боломжийг олгосон бүтэц, бүрэлдэхүүнтэй байна.

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн хугацаатай сонгодог. ТУЗ-ийн гишүүд дахин сонгогдох эрхтэй.

ХасБанкны ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2024 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дуусгавар болсон тул тус хурлаар ТУЗ-ийн гишүүнийг томилох асуудлыг хэлэлцсэн.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

Гишүүнээс чөлөөлөгдсөн	Шинээр томилогдсон
1. Ив Жако- ТУЗ-ийн ердийн гишүүн	1. Стюарт Холл- ТУЗ-ийн хараат бус гишүүн
	2. Доминик жак- ТУЗ-ийн ердийн гишүүн

ТУЗ-ийн хурал

Нийт хурлын тоо	Хурал	Цахим санал хураалт
23	7	16

Хэлэлцсэн асуудал	Баталсан тогтоолын тоо
67	53

Хурлын ирц		Цахим санал хураалтын оролцоо
100.00%	Стюарт Холл	100.00%
100.00%	Эми Чой	100.00%
71.42%	Н.Цэлмүүн	81.25%
100.00%	Б.Уламбаяр	93.75%
100.00%	Сюзанна Херринг Карр	100.00%
100.00%	Нираж Вэдва	100.00%
100.00%	Майкл Мадден	81.25%
80.00%	Доминиж Жак	69.23%
85.71%	Г.Цэвэгжав*	100.00%
100.00%	Анджей Витак	100.00%
100.00%	Албертус Браггинк	100.00%
100.00%	Санжай Гүпта	100.00%

*ГЗ бөгөөд ТУЗ-ийн гишүүн Г.Цэвэгжав эрүүл мэндийн шалтгаанаар ТУЗ-ийн 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хуралд оролцоогүй болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН

ТУЗ-ийн гишүүний хөлсний хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог. ТУЗ-ийн гишүүд ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хорооны хуралд оролцох болон холбогдох бусад үүрэг хариуцлагыг гүйцэтгэхтэй холбоотой хөлс авдаг ба энэ нь түүний оролцох шаардлагатай ТУЗ, түүний хороо болон хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцээс хамааран тодорхойлогдоно. Хөлсийг улирал тутамд олгоно. Банкинд давхар албан тушаал хашдаггүй ТУЗ-ийн гишүүн хувьцаа эзэмшигчдээс тогтоосон хөлс, хороо удирдсантай холбогдуулан олгох нэмэгдлээс өөр бусад хөлс, шагнал урамшуулал авдаггүй.

ТУЗ-ийн гишүүний хөлсийг 2024 оны 4 дүгээр сарын 29-ны хувьцаа эзэмшигчдийн хурлаар шинэчлэн тогтоосон. Тогтоолтой [эндээс](#) танилцах боломжтой.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮНЭЛГЭЭ

Зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ нь хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр ТУЗ-ийн үйл ажиллагааны

үнэлгээг хийдэг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн ТУЗ-ийн гишүүд бусад гишүүдийн үнэлгээг тус бүр хийдэг.

ТУЗ-ийн үйл ажиллагааны болон гишүүдийн үнэлгээ нь компанийн засаглалын сайн туршлагад тооцогддог бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийг бэхжүүлэх, сул талыг олж илрүүлэх, чадамжийг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, бүтцийн талаар гишүүдийн дунд санал солилцох боломж олгодог.

2024 онд ТУЗ нь 2023 оны 3 дугаар сараас 2024 оны 3 дугаар сар хүртэл хугацааг хамарсан ТУЗ ба ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээг хийж, тус үнэлгээний дүнд үндэслэн төлөвлөгөө боловсруулж, авах 8 арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлж ажиллалаа.

Эдгээрээс онцлон дурьдвал, Нэр дэвшүүлэх үйл явцын ил тод байдлыг сайжруулах арга хэмжээний хүрээнд ЗНДЦУХ-ны гишүүн бус ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшүүлэх үйл явцын талаар дэлгэрэнгүй тайлан бэлтгэх талаар зохицуулалтыг журамлаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх ерөнхий журмыг 2024 оны 11 дүгээр сард шинэчлэн баталсан байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН СУРГАЛТ

ТУЗ-ийн үнэлгээний дараах авах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу, гадаад гишүүдэд Монгол Улсын онцлогийн талаарх мэдлэг олгох сургалт зохион байгуулах арга хэмжээний дагуу холбогдох сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр танхим болон цахим хосолсон байдлаар, 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр тус тус цахимаар зохион байгуулав.



Шинэ гишүүдийн тухайд, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг компанийн засаглалын сургалтад нэн тэргүүнд хамруулж (хэрэв энэ чиглэлээр аливаа сургалтад хамрагдаж байгаагүй бол) Монгол Улсын Компанийн тухай хууль, компанийн засаглалын онцлогийг таниулах сургалтыг зохион байгуулдаг.

Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход ХасБанкны багц баримт бичгүүд болох өмнөх оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан болон бусад холбогдох бичиг баримтуудыг хүргүүлж танилцах боломжийг олгодог.

ТУЗ-ийн гишүүд нь гүйцэтгэх захиралтай тохиролцон, Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүй байдлаар Банкны удирдлагуудтай уулзалт зохион байгуулж асууж тодруулах, мэдээлэл авах нөхцөл боломжоор хангагддаг.

9. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо	Эрсдэлийн удирдлагын хороо	Аудитын хороо
Дарга: Майкл Мадден	Дарга: Албертус Браггинк	Дарга: Б.Уламбаяр (хараат бус гишүүн)
Гишүүд: Н.Цэлмүүн Б. Уламбаяр (хараат бус гишүүн) Эми Чой (хараат бус гишүүн) Нираж Вэдва (хараат бус гишүүн) Стюарт Холл (хараат бус гишүүн)	Гишүүд: Доминик Жак Б. Уламбаяр (хараат бус гишүүн) Эми Чой (хараат бус гишүүн) Нираж Вэдва (хараат бус гишүүн) Стюарт Холл (хараат бус гишүүн)	Гишүүд: Анджей Витак Сюзанна Карр Эми Чой (хараат бус гишүүн) Нираж Вэдва (хараат бус гишүүн) Стюарт Холл (хараат бус гишүүн)

ТУЗ-ийг дэргэдэх хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байна.

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж буй гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн Хороодод гишүүнээр ажилладаггүй.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг.

Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана.

ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

Чиг үүрэг: Зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

Хорооны дүрэмтэй доорх холбоосоор орж танилцана уу:
<https://www.xacbank.mn/page/board-committees>

Үйл ажиллагааны тайлан

Нийт хурлын тоо

6

Хурлын ирц (хувиар)

Майкл Мадден		83.33%
Н.Цэлмүүн		100.00%
Б. Уламбаяр		100.00%
Эми Чой		100.00%
Нираж Вэдва		100.00%
Стюарт Холл		100.00%

Хэлэлцсэн асуудал

21

Засаглалын Кодексийн дагуу дараах бодлого, журмыг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах саналыг ТУЗ-д хүргүүлэв:

- ТУЗ-ийн үнэлгээний журам (2019)-ын шинэчилсэн найруулга
- Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам
- Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлдэх бодлогыг
- ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх ерөнхий журам (шинэчилсэн найруулга)

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Чиг үүрэг: Эрсдэлийн удирдлага дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материаллаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг асуудлаар ТУЗ-д зөвлөх, түүнчлэн ТУЗ-өөс эрх шилжүүлсний дагуу зарим шийдвэр гаргах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай.

Хорооны дүрэмтэй доорх холбоосоор орж танилцана уу:
<https://www.xacbank.mn/page/board-committees>

Үйл ажиллагааны тайлан

Нийт хурлын тоо

20

Хурлын ирц (хувиар)

Албертус Браггинк		100.00%
Доминик Жак		100.00%
Б. Уламбаяр		100.00%
Эми Чой		100.00%
Нираж Вэдва		100.00%
Стюарт Холл		100.00%

Хэлэлцсэн асуудал

36

Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар дараах асуудлуудыг тогтмол хэлэлцдэг:

- ХасБанкны эрсдэлийн тайлан
- Хянан нийцүүлэлтийн явцын мэдээ/ тайлан
- Зээлийн тойм
- Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах санал

АУДИТЫН ХОРОО

Чиг үүрэг: Дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, ердийн бус хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг.

Аудитын хорооны дүрмийг 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан. Хорооны дүрэмтэй доорх холбоосоор орж танилцана уу:
<https://www.xacbank.mn/page/board-committees>

Үйл ажиллагааны тайлан

Нийт хурлын тоо

6

Хэлэлцсэн асуудал

36

Хурлын ирц (хувиар)

Б.Уламбаяр	100.00%
Нираж Вэдва	100.00%
Эми Чой	100.00%
Анджей Витак	100.00%
Сюзанна Херринг Карр	100.00%
Стюарт Холл	100.00%

Аудитын хорооны хурлаар дараах асуудлуудыг тогтмол хэлэлцдэг:

- Аудитын тайлан
- Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан
- Банкны холбогдох этгээдүүдийн улирлын тайлан (Монгол Банкны журам
- Шүгэл үлээхтэй холбогдон гарсан тохиолдлуудын 2024 оны тайлан

10. ЁС ЗҮЙН КОДЕКС, СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ БА ТОЛИЛУУЛГА

Банкны ёс зүйн хэм хэмжээ нь чин сэтгэлээсээ байх, үнэнч байх, шударга байх, ил тод байх зарчмуудад үндэслэдэг. ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан “ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд өөрийн холбогдох этгээдийн мэдээллийг өөрчлөлт орох тухай бүр мэдэгдэхээс гадна **жилд 2 удаа** бататгах толилуулгын хуудсыг үйлдэж, сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан тогтоох боломжийг ханган ажиллаж байна. Мөн түүнчлэн, ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхлын зөрчил байвал түүнийгээ мэдэгддэг ба Компанийн тухай хуулийн дагуу уг гишүүн санал хураалтад оролцдоггүй.

ХасБанк нь “Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам”-ыг баримтлан өөрийн ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлөөр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх, улмаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэн ажиллаж байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нь холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

ХасБанк нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдэд зөвхөн харилцагчид санал болгох нөхцөлтэй ижил нөхцөлөөр үйлчилгээ үзүүлж байна.

Иймд, хэрэв тухайн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдэд болон олгосон нийт зээлийн хэмжээ 300.0 сая төгрөгөөс бага бол (орон сууцны зээлийн тухайд 200.0 сая төгрөгөөс бага бол) тухайн этгээдэд ердийн журмаар зээл олголт хийгдэх бөгөөд ийнхүү шийдвэрлэгдсэн хэлцлүүдийг улирал бүр ТУЗ хянан үзэж батламжилдаг. Харин, дээрх дүнгээс их, эсхүл харилцагчийн нөхцөлөөс өөр нөхцөлтэй тохиолдолд зөвхөн ТУЗ урьдчилан хянаж баталснаар үйлчилгээ үзүүлнэ.

ТУЗ-ийн эрсдэлийн удирдлагын хороо нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдийн хэлцэлд хяналт тавин, ТУЗ-өөр ийнхүү тухай бүр шийдвэрүүлдэг ба ингэхдээ, Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг баримтлан ажиллаж байна.


Тайлант хугацаанд батлагдсан сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийн жагсаалт

№	Хамаарал	Хэлцлийн дүн (төгрөг)
1	Банкны эрх бүхий албан тушаалтан	10,000,000
2	Банкны холбогдох этгээд	580,000,000
3	Банкны холбогдох этгээд ¹	19,270,100,000
4	Банкны эрх бүхий албан тушаалтан	100,000,000
5	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
6	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
7	Банкны эрх бүхий албан тушаалтан	50,000,000
8	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	45,000,000
9	Банкны эрх бүхий албан тушаалтан	50,000,000
10	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	173,000,000
11	Банкны эрх бүхий албан тушаалтан	20,000,000
12	Банкны эрх бүхий албан тушаалтан	200,000,000
13	Банкны эрх бүхий албан тушаалтан	20,000,000

¹ Банкны холбогдох этгээдээр бүртгэгдсэн энэхүү хуулийн этгээд нь банкны холбогдох этгээд биш болсон. Иймд, энэхүү хэлцлийг 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар холбогдох этгээдийн хэлцэл гэж тооцохгүй болно.


Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.

11. КОМПАНИЙН БҮТЭЦ



Төлөөлөн Удирдах Зөвлөл

Гүйцэтгэх захирал



12. УДИРДЛАГЫН БАГ



Гүмэнжавын Цэвэгжав
ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдэл
Гүйцэтгэх захирал

ХасБанканд: 2011 оноос
Ажлын туршлага: 20 жил



Ганзоригийн Эрдэнэбаяр
Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч
бөгөөд Санхүү хариуцсан захирал

ХасБанканд: 2005 оноос
Ажлын туршлага: 19 жил



Энэбишийн Уламбаяр
Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд
Иргэдийн банк хариуцсан захирал

ХасБанканд: 2013 оноос
Ажлын туршлага: 24 жил



Бавааны Еркин
Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд
Байгууллагын банк хариуцсан захирал

ХасБанканд: 2002 оноос
Ажлын туршлага: 21 жил



Серикжаны Дауренбек
Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд
Лизинг хариуцсан захирал

ХасБанканд: 2000 оноос
Ажлын туршлага: 26 жил



Илия Аврамов
Эрсдэл хариуцсан захирал

ХасБанканд: 2019 оноос
Ажлын туршлага: 26 жил



Ганзоригийн Зул
Үйл ажиллагаа хариуцсан захирал

ХасБанканд: 1999 оноос
Ажлын туршлага: 25 жил



Хүрэлбаатарын Өнөрбат
Мэдээллийн технологи
хариуцсан захирал

ХасБанканд: 2012 оноос
Ажлын туршлага: 21 жил



Нямсүрэнгийн Мөнхцэлмэг
Хууль хариуцсан захирал / ТУЗ-ийн
нарийн бичгийн дарга

ХасБанканд: 2022 оноос
Ажлын туршлага: 17 жил



Энхбаярын Ундармаа
Ерөнхий Аудитор
/ТУЗ-ийн Аудитын хороонд шууд тайлагнадаг/

ХасБанканд: 2008 оноос
Ажлын туршлага: 26 жил

ХасБанканд
ажилласан
дундаж жил

15

Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал

Гүйцэтгэх захирлын цалин хөлс нь үндсэн цалин, жилийн гүйцэтгэлд суурилсан урамшууллаас бүрдэнэ. ТУЗ нь Гүйцэтгэх захирлын гэрээний нөхцөл болзол, Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн талаар гаргасан Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны зөвлөмжийг үндэслэн Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлгээ хийдэг. Банкны стратегийн зорилго, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд² тулгуурласан энэхүү үнэлгээ нь түүнд олгох цалин хөлсийг тодорхойлох үндэслэл болно.

Гүйцэтгэх захирлын 2024 оны ажлын гүйцэтгэлийг ТУЗ болон ЗНДЦУХ хэлэлцээд түүнд олгох 2024 оны гүйцэтгэлд суурилсан урамшууллыг баталсан.

²Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурын нэр төрөл нь байгууллагын нууц тул энд дэлгэрэнгүй тусгаагүй болно.



☎ (976)-75771888-(888)

✉ investor-relations@xacbank.mn

🌐 <https://www.xacbank.mn>



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 03 сарын 05 өдөр

№ R-2025-09

Улаанбаатар хот

2024 оны үйл ажиллагааны тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу, ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны гүйцэтгэх удирдлага Банкны 2024 оны үйл ажиллагааны тайлан ("2024 оны үйл ажиллагааны тайлан")-г энэхүү тогтоолд хавсаргасан байдлаар бэлтгэснийг ТУЗ хянан хэлэлцээд тус тайлан нь Банкны үйл ажиллагааны үр дүнг бодитоор ил тод илэрхийлсэн гэж дүгнэсэн ("ТУЗ-ийн дүгнэлт") болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

- Банкны 2024 оны үйл ажиллагааны тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт Банкны хувьцаа эзэмшигчдэд өргөн мэдүүлэхээр баталсугай.
- Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд 2024 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлтгэх, танилцуулах зэрэг энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



Хурлаар шийдвэрлэх хоёрдугаар асуудал:

ХасБанкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай

САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Санхүүгийн хураангуй тайланг ХасБанк ХК ("Банк")-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу Банкны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын шаардсан бүх тодруулгуудыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан ба аудиторын дүгнэлт нь Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан аудитлагдсан санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд дараахыг багтаасан.

- Аудитын онцгойлсон асуудал - Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох "Зээлийн үнэ цэнийн бууралт" байсан.

Санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн хураангуй тайланг "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Банкны удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС") 810 буюу "Санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил"-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.



Ernst & Young Mongolia Audit LLC
Эрнст энд Янг Монголия Аудит Ххк
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Буланбайн Хабылхайрат
Захирал

Баталсан



Адриан Чу
Партнер


Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2025 оны 3 дугаар сарын 17

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн

➤ **Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлан**


	2024 мян.төг	2023 мян.төг
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүү болон түүнтэй адилтгах орлого	703,265,483	526,401,210
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүү болон түүнтэй адилтгах орлого	12,974,358	12,159,064
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(396,254,799)	(278,569,871)
Хүүгийн цэвэр орлого	319,985,042	259,990,403
Хураамж ба шимтгэлийн орлого	44,072,758	36,904,130
Хураамж ба шимтгэлийн зардал	(15,935,071)	(13,509,402)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	28,137,687	23,394,728
Арилжааны цэвэр ашиг	15,983,088	13,612,534
БҮЦАА-д бүртгэсэн бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого	7,639,026	5,376,193
Үйл ажиллагааны бусад цэвэр орлого	10,962,475	4,777,551
Үйл ажиллагааны нийт орлого	382,707,318	307,151,409
Үнэ цэнийн бууралтын цэвэр буцаалт	2,129,641	8,118,712
Үйл ажиллагааны цэвэр орлого	384,836,959	315,270,121
Үйл ажиллагааны зардал	(154,856,979)	(125,711,392)
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	484,712	1,129,888
Татварын өмнөх ашиг	230,464,692	190,688,617
Орлогын татварын зардал	(58,784,404)	(48,629,972)
Тайлант жилийн ашиг	171,680,288	142,058,645
Бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):		
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:</i>		
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн нөөцийн өөрчлөлт, татварын дараах	(856,106)	277,438
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах	(856,106)	277,438
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	170,824,182	142,336,083
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):		
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	163.10	138.05
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	163.10	138.05

2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөн гарын үсэг зурав.




ГАНЗӨРИГИЙН ЭРДЭНЭБАЯР
(Санхүү хариуцсан захирал)

Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.



	2024 мян.төг	2023 мян.төг
ХӨРӨНГӨ		
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	33,914,061	358,359,279
Монголбанк дахь заавал байлгах нөөц	397,890,873	239,378,375
БУЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд		
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	10,050,723	56,800,918
Санхүүгийн хэрэгслүүд	112,300,780	110,309,146
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	209,855,668	93,116,520
БУЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө		
Өмчийн хэрэгслүүд	3,910,731	5,052,206
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө		
Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	776,096,768	393,769,064
Урвуу репо хэлцэл	-	99,740,669
Өрийн хэрэгслүүд	1,133,892,280	960,070,624
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3,472,735,003	2,627,234,410
Бусад хөрөнгө	61,573,787	71,277,148
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	1,089,949	1,387,250
Үндсэн хөрөнгө ба ашиглах эрхтэй хөрөнгө	79,706,337	75,388,849
Биет бус хөрөнгө	16,833,961	18,667,114
Хойшлогдсон татварын хөрөнгө	11,942,798	8,870,069
НИЙТ ХӨРӨНГӨ	6,321,793,719	5,119,421,641
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
БУЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд		
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	9,542,837	14,332,115
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр		
Репо хэлцэл	-	149,611,113
Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж	276,333,956	36,937,419
Харилцагчдын харилцах, хадгаламж	3,424,786,562	2,876,117,299
Зээлээр авсан санхүүжилт	1,727,756,398	1,238,768,595
Хойшлогдсон нөхцөлт хандив	12,397,895	12,564,957
Түрээсийн өр төлбөр	7,233,884	7,675,609
Бусад өр төлбөр	105,974,775	131,592,516
Орлогын албан татварын өглөг	26,164,657	29,759,280
НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,590,190,964	4,497,358,903
ЭЗДИЙН ӨМЧ		
Энгийн хувьцаа	105,270,000	105,270,000
Халаасны хувьцаа	(29,668)	-
Нэмж төлөгдсөн капитал	30,388,871	30,586,768
Нөөцүүд	80,566,643	86,418,906
Хуримтлагдсан ашиг	515,406,909	399,787,064
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	731,602,755	622,062,738
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	6,321,793,719	5,119,421,641

2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрхийн дагуу энэхүү тайланг нийтлэхийг зөвшөөрөн гарын үсэг зурав.



ГАНЗОРИГИЙН ЭРДЭНЭБАЯР
(Санхүү хариуцсан захирал)

Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Банкны аудитлагдсан санхүүгийн тайлан дахь Санхүүгийн байдлын тайлан болон Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ



2025 оны 03 сарын 17 өдөр

№ R-2025-17

Улаанбаатар хот

2024 оны аудитлагдсан
санхүүгийн тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 03 дугаар сарын 13-17-ны өдрийн хооронд зохион байгуулсан цахим санал хураалтаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны СТОУС болон НББОУС-ын дагуу бэлтгэсэн 2024 оны санхүүгийн тайланг Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК хянаж ("2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан") зөрчилгүй гэж дүгнэсэн болохыг;
2. Банкны Аудитын хороо 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар хэлэлцээд 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан гэж үзэн батлах саналыг ТУЗ-д хүргүүлснийг; мөн
3. ТУЗ нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг Аудиторын дүгнэлтийн хамт хянан хэлэлцээд тус тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан гэж дүгнэсэн ("ТУЗ-ийн дүгнэлт") болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. Банкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталж Банкны хувьцаа эзэмшигчдэд танилцуулсугай.
2. Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав болон Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаяр нарт 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланд гарын үсэг зурах эрх олгосугай.
3. Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав болон Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаяр нарт 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлтгэх, танилцуулах зэрэг энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



Хурлаар танилцуулах асуудал:

ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ТАЙЛАН



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ,

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн нэрийн өмнөөс 2024 оны санхүүгийн жилийн тайланг танилцуулахдаа таатай байна.

Бидний зүгээс Төлөөлөн удирдах зөвлөлийн стратегийн алсын хараа, засаглалын манлайлал, тогтвортой хөгжлийн төлөөх хүчин чармайлтад чин сэтгэлээсээ талархаж буйгаа юун түрүүнд илэрхийлье. Мөн банкны стратегийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд сэтгэл зүрхээ зориулан ажилласан

Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын баг хамт олон болон ажилтнууддаа талархал илэрхийлж байна. Тэдний хүчин чармайлтаар ХасБанк дахин нэг жил ийнхүү өндөр амжилтыг үзүүлээд байна.

Санхүүгийн гол үзүүлэлтүүд

ХасБанкны 2024 онд үзүүлсэн өндөр амжилт нь санхүүгийн гол үзүүлэлтүүдэд дараах байдлаар тусгалаа олсон.

- Татварын дараах цэвэр ашиг: 171.7 тэрбум төгрөг (өмнөх оноос 20.9%-иар өссөн)
- Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ: 2% (тогтмол бууруулан ажиллаж байна)
- Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа: 19.2%
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа: 38.4%
- Нийт зээлийн багц өмнөх оноос 34.5%-иар өссөн.
- Харилцах, хадгаламжийн хэмжээ 19.1%-иар өссөн.
- Зээлжих зэрэглэл: Moody's болон Fitch олон улсын байгууллагаас үнэлгээг нэг шатлалаар ахиулж, тогтвортой төлвийг хэвээр хадгалсан.

Түүнчлэн ХасБанк нь 2020 оноос хойш тогтмол, сайн өсөлтийг үзүүлж буй нь жилийн дундаж өсөлтийн нийлмэл хувь (ЖДӨНХ)-д мөн тусгалаа олсон. Энэ сүүлийн 4 жилийн хугацаанд ХасБанкинд эерэг өөрчлөлтийг бий болгоход хувь нэмрээ оруулагч алсын хараа, төлөвлөгөөг тодорхойлсон Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод банкныг удирдлагаар хангаж ажилласан Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүддээ мөн талархлаа илэхийлэх нь зүйтэй.

- Үйл ажиллагааны ашиг - ЖДӨНХ 30.3%.
- Татварын дараах цэвэр ашиг: 2020 онд цэвэр ашиг 33.7 тэрбум төгрөг байснаас 2024 онд 171.7 тэрбум төгрөг болж өссөн (ЖДӨНХ: 50.2%).
- Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 2020 онд 12.2% байснаас 2024 онд 25.7% болж өссөн.
- Нийт хөрөнгө - ЖДӨНХ 17.2%.

Стратегийн санаачилга ба Дижитал шилжилт

ХасБанк өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний багцийг сайжруулж, харилцагчдын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээг хангах зорилгоор шинийг санаачилж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсээр байна. Үүнд:

- Асуудалгүй, Зорилготой хадгаламж, Амар зээл, Slice зээл зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсэн.
- Тэмүүлэл, Хасын Хүлэгүүд, Олимп, Ирээдүй болон түншлэгч байгууллагуудын карт болох картын шинэ бүтээгдэхүүн танилцуулсан.

Эдгээр санаачилгуудын тусламжтайгаар ХасБанкны харилцах, зээлийн болон хадгаламжийн харилцагчдын бааз ихээхэн өргөжсөн билээ.

Мөн банк нь дижитал шилжилтэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж, харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх үүднээс хэрэглэхэд хялбар дижитал интерфэйс, санхүүгийн бүтээгдэхүүнд саадгүй хандах боломж, мэдээлэл шууд боловсруулах технологийг нэвтрүүлсэн. Цаашлаад, маркетинг идэвхжүүлэлт, брэнд таниулах хүчин чармайлтууд, Фейсбүүк, Инстаграм зэрэг нийтийн сүлжээний платформуудыг хөшүүрэг болгон ашиглах, салбарын арга хэмжээнүүдэд оролцох зэрэг үйл ажиллагаануудыг хийж ХасБанкны зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлээд байна.

Засаглал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн засаглалын хүрээнд, 2024 оны турш идэвхтэй оролцоотойгоор дараах хуралдаануудыг зохион байгуулж, холбогдох шийдвэрийг гаргасан болно:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 хурал хуралдуулсан.
- 16 цахим санал хураалт явуулсан.
- 53 тогтоол баталсан.

Засаглалын асуудлаар хийж гүйцэтгэсэн гол ажлуудаас дурдвал:

- Бие даасан, тогтсон процессын дагуу, эрсдэлийг хамгийн бага түвшинд барих үүднээс холбогдох этгээдтэй хэлцэл хийх ажиллагаанд хатуу хяналт тавьж ажилласан.
- Хууль тогтоомжийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэгч байгууллага болохын хувьд Санхүүгийн Зохицуулах Хорооноос банкны засаглалыг 93.1% буюу сайн гэж үнэлсэн нь 2023 онтой харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна.
- Хөрвөх чадваргүй хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохицуулагч байгууллагын зөвшөөрлийн үндсэнд Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг ил тодоор батлан хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрөөр дамжуулан жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалж ажилласан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хараат бус гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн аливаа хэлэлцүүлэг болон шийдвэр гаргах ажиллагаанд тэгш оролцох бололцоог хангаж, засаглалын сайн тогтолцоог бэхжүүлэн ажилласан.
- Банкны тухай хуулийн шаардлагад нийцүүлэн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх ажиллагааг хийж гүйцэтгэж байна.

Төгсгөлийн үг

ХасБанк нь хүний нөөцийн эргэцийн харьцааг бага түвшинд хадгалж, өндөр бүтээмжийг хөхиүлэн дэмжих байдлаар ажлын эерэг, бүтээлч орчныг цогцлоон ажиллаж байна. Богино, дунд, урт хугацааны тодорхой стратеги, чадварлаг удирдлагын баг, ажилтнуудтай болохын хувьд ХасБанк нь төлөвлөсөн зорилтоо биелүүлж, өсөлтийн хурдаа тогтвортой хадгалах бүрэн бололцоотой хэвээр болно.

Бидэнд итгэлээ хүлээлгэн, дэмжлэг, туслалцаа үзүүлсэн нийт оролцогч талууддаа талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,



Нираж Вэда

(Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн)

Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт хараат бус гишүүдийн нэрийн өмнөөс



Хурлаар шийдвэрлэх гуравдугаар асуудал:

**ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг
хуваарилах тухай**

Агуулга


2024 оны 2-р хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах санал

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг болон ХасБанк ХК-ийн дүрмийн 8.6 (ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн R-2025-03 тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдэд дараах байдлаар ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр тараахыг санал болгож байна.


Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг:	27.00 төгрөг
Ногдол ашгийн нийт дүн:	28.42 тэрбум төгрөг
Ногдол ашиг тараах огноо:	2025 оны 04-р сарын 30*: холбогдох бүх шийдвэр, зөвшөөрөл гарснаар
Ногдол ашиг тараах хэлбэр:	ҮЦТХТ-өөр дамжуулан нэрийн дансаар
Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр:	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2025 оны 04-р сарын 10-ны өдрийг Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоох

Ногдол ашгийн түүхэн мэдээлэл

Тайлант хугацаанд ХасБанк нь хувьцаа эзэмшигчдэдээ 61.0 тэрбум төгрөгийн (2023 оны цэвэр ашгаас 42.1 тэрбум төгрөг, 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 18.9 тэрбум төгрөг) ногдол ашиг тус тус тараасан байна. Харин 2024 оны сүүлийн хагас жилээс нэгж хувьцаанд 27 төгрөг буюу нийт 28.4 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд тарааснаар 2024 оны нийт ашгаас нэгж хувьцаанд 45 төгрөг буюу нийт 47.4 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр тараахаар байна.



Ногдол ашиг тараах хугацаа



* Монголбанкнаас зөвшөөрч, Банкны Дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчид эцэслэн баталсны дараагаар ногдол ашгийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөрт багтаан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ("ҮЦТХТ")-д шилжүүлэхээр төлөвлөж байна. Үүний дараагаар ҮЦТХТ ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн нэрийн дансанд хуваарилан байршуулна.

** Банк нь ногдол ашиг тараах эсэх асуудалд зөвшөөрөл авахаар Монголбанканд 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр холбогдох журмын дагуу хүсэлт гаргасан бөгөөд 30 хоногийн дотор Монголбанкнаас албан хариу авахаар тооцож байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 02 сарын 18 өдөр

№ R-2025-03

Улаанбаатар хот

2024 оны жилийн эцсийн ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг болон ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалтад тус тус үндэслэн, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 болон 46.8 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ нь татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор шийдвэрлэх шаардлагатай болохыг;
2. Банк нь 2024 оны хагас жилийн аудитлагдсан тайланд үндэслэн эхний хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18.00 (арван найм) төгрөг хуваарилсан болохыг;
3. Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2024 оны санхүүгийн жилийн эцсийн ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг ("Жилийн эцсийн ногдол ашиг") мөнгөн хэлбэрээр доорх дүнгээр хуваарилахыг ТУЗ-д санал болгосон ба хуваарилах ногдол ашгийн хэмжээ нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан гарсны дараа бүрэн баталгаажихыг; мөн
4. Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу ногдол ашиг хуваарилах эсэх нь стратегийн асуудал бөгөөд хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэх тул ТУЗ нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээр баталгаажсан тохиолдолд дор дурдсан дүнгээр Жилийн эцсийн ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан Жилийн эцсийн ногдол ашигт нэгж хувьцаанд 27.00 (хорин долоо) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("ХЭЭХ")-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг Жилийн эцсийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Вөб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

3. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Жилийн эцсийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлж эхэлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



Хурлаар шийдвэрлэх дөрөвдүгээр асуудал:

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХАСБАНКНЫ ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ: (А) ЗНДЦУХ-Г ХУВААХ

- Санхүүгийн Зохицуулах Хороо нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахдаа Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5 болон 81.6 дахь хэсэгт тус тус үндэслэн нэр дэвшүүлэх чиг үүргийг цалин урамшууллын чиг үүргээс тусгаарлах зөвлөмжийг ирүүлсэн болно.
- Тиймээс одоогийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо **(“ЗНДЦУХ”)-г бие даасан хоёр тусдаа хороо болгон хуваах** шаардлага үүссэн (доор графикаар харуулав).



- ЗНДЦУХ-г салган хуваахтай холбоотой өөрчлөлтүүдийг тусгахын тулд ХасБанкны Дүрэмд дараах байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.	8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос Нэр дэвшүүлэх хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.	8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.
8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.	8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын, болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны <u>Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны</u> гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.	8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 25 оны 03 сарын 05 өдөр

№ R-2025-08

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвлөмж хүргүүлэх тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ") нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахдаа Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5 болон 81.6 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн нэр дэвшүүлэх чиг үүргийг цалин урамшууллын чиг үүргээс тусгаарлах зөвлөмжийг ирүүлсэн болохыг;
- ТУЗ дээрх чиг үүргийг хоёр тусдаа хороонд салган хуваарилах нь Банкны ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэн болохыг; мөн
- Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог: (а) ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, залгамж халааг төлөвлөн зохион байгуулах чиг үүрэг бүхий Нэр дэвшүүлэх хороо болон (б) компанийн засаглалын бодлого журам, ТУЗ-ийн бүтэц, цалин хөлсний бодлого, урамшууллын бүтцийг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Засаглал, цалин урамшууллын хороо гэсэн бие даасан хоёр хороо болгон салган хуваах асуудлыг тусгах байдлаар Банкны Дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, ХасБанкны Дүрмийн дараах хэсгүүдэд доорх нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад	8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос <u>Нэр дэвшүүлэх хорооноос</u> тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ,

дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.	МХБ-ээс баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.	8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.
8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.	8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын, болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.	8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.

2. Банкны Дүрэмд дээр дурдсан нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар Хувьцаа эзэмшигчдэд мэдүүлсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчид баталсны дараа шинээр байгуулагдсан хороо тус бүр өөрийн шинэчилсэн дүрмийг ТУЗ-өөр батлуулж, эдгээр дүрмийн дагуу тус бүрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг үүрэг болгосугай. ТУЗ холбогдох хууль тогтоомж болон засаглалын сайн туршлагад нийцүүлэн Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хорооны дарга, гишүүдийг томилно. Хороод тус бүр холбогдох дүрэмд заасны дагуу өөрийн үйл ажиллагаа, тайлан, зөвлөмжийг ТУЗ-д тогтмол танилцуулж ажиллахыг үүрэг болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчид баталсны дараа дотоод засаглалын бодлого журам, үүн дотор ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон холбогдох бусад баримт бичгүүдэд оруулах

нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, ТУЗ-өөр батлуулахыг ТУЗ-ийн Ажлын албанд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

A black ink signature, appearing to be "Н.Мөнхцэлмэг", written in a cursive style.

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХАСБАНКНЫ ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ: (Б) АХМАДЫН САНГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

- ХасБанк нь Ахмад настны тухай хууль (2017)-ийн дагуу Ахмадын сан байгуулсан. Энэхүү сан нь Банкинд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настанд дэмжлэг, тусламж үзүүлэх зорилготой болно;
- Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хуульд** 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр **нэмэлт оруулсны үндсэнд:**
 - Ахмадын сан байгуулах болон түүнд компанийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувь (3%)-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг хуваарилан төвлөрүүлэх асуудлыг Компаниуд өөрсдийн дүрэмдээ тусгайлан тусгах үүрэг хүлээсэн;
- Иймээс ХасБанкны Дүрмийг хууль тогтоомжийн **өөрчлөлтөд нийцүүлэх**, тус дүрэмд Ахмадын сангийн **зохицуулалтыг тусгах** шаардлагатай болно.
- ХасБанкны Дүрэмд дараах агуулга бүхий **5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг нэмэх** юм:

Дүрэмд оруулах нэмэлт хэсэг

- 5.5. Банк нь Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан Ахмадын сантай байх ба санг Банкны ахмадын тооноос хамааран Банкны цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 03 сарын 05 өдөр

№ R-2025-11

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт
оруулах зөвлөмж хүргүүлэх тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банк нь Ахмад настны тухай хууль (2017)-ийн дагуу Банкинд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настанд дэмжлэг, тусламж үзүүлэх зорилгоор байгуулсан Ахмадын сантай болохыг;
2. Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт оруулж, компаниудад өөрийн дүрэмдээ Ахмадын сан байгуулах болон түүнд компанийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувь (3%)-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг хуваарилан төвлөрүүлэх асуудлыг тус тус тусгайлан тусгахыг үүрэг болгосныг; мөн
3. ТУЗ нь Банкны Дүрмийг хууль тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэх, тус дүрэмд Ахмадын сангийн зохицуулалтыг тусгахаар санал болгож буй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, ХасБанкны Дүрэмд дараах агуулга бүхий 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг нэмсүгэй:

Нэмэх заалт

5.5. Банк нь Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан Ахмадын сантай байх ба санг Банкны ахмадын тооноос хамааран Банкны цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ.

2. Банкны Дүрэмд дээр дурдсан нэмэлтийг оруулахаар Хувьцаа эзэмшигчдэд мэдүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn



Хурлаар шийдвэрлэх тавдугаар асуудал:

Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

НЭГТГЭХ ГЭРЭЭ БОЛОН НЭГТГЭХ НӨХЦӨЛ, ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Банкны тухай хуульд зааснаар системийн банк бүр “аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа нь тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх” нөхцөлийг биелүүлэх ёстой. Банкууд энэ шаардлагыг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө хангасан байх үүрэгтэй.

ХасБанкны Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлыг хэлэлцээд ХасБанкны толгой компани болох Тэнгэр санхүүгийн нэгдэл ХХК (“ТСН”)-ийг ХасБанкинд нэгтгэх нь зүйтэй гэж 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр шийдвэрлэсэн. Ингэснээр ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болж, Банкны тухай хуулийн шаардлагыг хангах юм.

Монголбанкнаас нэгтгэх өөрчлөн байгуулалтын хүсэлтийг хянах явцад ТСН-ийн нийт гаргасан хувьцааны 20.39%-ийг өөрийн охин компани (МАК Инвест Кэй Эф Ти)-иар дамжуулан эзэмшдэг “Монголын Алт” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсон. Уг өөрчлөлтийг Банкны тухай хуульд нийцүүлэх шаардлагатай болсон тул ТСН дэх тэдний хөрөнгө оруулалтын бүтцийг өөрчилж, нэг эцсийн өмчлөгчийг ТСН дэх эцсийн өмчлөгчийн бүтцээс хасах өөрчлөн байгуулалт хийгдээд байна.

Энэхүү өөрчлөлтийн дагуу ТСН-ийн 20.39%-ийг МАК Инвест Кэй Эф Ти-ийн оронд МАК Инвест Эс Жи эзэмших болсон.

Ийнхүү ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан, ХасБанк болон ТСН хооронд байгуулсан Нэгтгэх гэрээнд тус өөрчлөлтийг тусгах шаардлагатай болсон тул, Нэгтгэх гэрээ болон түүнд холбогдуулан баталсан Нэгтгэх нөхцөл, журамд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар ТУЗ-ийн R-2025-10 тоот тогтоолоор зөвлөмж болгосны дагуу, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж буй болно.

Нууц баримт
Эх хувь



ӨМГӨӨЛЛИЙН
БАТБАЯР ЭНД
ПАРТНЭРС ХХН

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 15, Монгол ТВ цамхаг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахим шуудан: contact@bnp.mn. Веб: www.bnp.mn

ХАСБАНК ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЦЭВЭГЖАВ

Огноо: 2025.03.25
Дугаар: BNP-34/25
Утга: Хуулийн дүгнэлтийн хураангуй



ХАСБАНК ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХТАЙ
ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛИЙН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ

Нэг. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх асуудлаар

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын хувьд ХасБанк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны [●] сарын [●]-ны өдрийн ээлжит хурлын №[●] тоот [●] тогтоол гарсан байна.

[Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр гарснаар энэ хэсгийн дүгнэлт бичигдэнэ.]

Хоёр. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, эзэлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:

ХасБанк ХК нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг өөртөө нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдахдаа гэрээний нөгөө талд албан бичгээр урьдчилсан мэдэгдэж, хариу авсан байхыг эзэлийн гэрээнүүдийн дагуу шаардсан байх тул ХасБанк ХК нь гэрээний үүрэг хэрэгжүүлэн нэгтгэх замаар Банкны хэлбэрийг өөрчлөх талаар албан ёсны мэдэгдлийг эзэлдүүлэгч талуудад хүргүүлж, хариу авсан байхыг Хуулийн фирмийн зүгээс зөвлөж байна.

Банкны иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан худалдах, худалдан авах гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, даатгалын гэрээ болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгээгүй байна гэж дүгнэлээ.

Гурав. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:

Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлд заасныг үндэслэн үзвэл ХасБанк ХК-ийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт активын 25 хувийн дүн болон



Гүйцэтгэх захирлын Батламж гаргах тухай албан бичигт үндэслэн гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар Банк нь их хэмжээний хэлцэл байгуулаагүй гэж Хуулийн фирмийн зүгээс дүгнэлээ.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасныг үндэслэн үзвэл гэрээ, хэлэлцээрийг тасалбар болгосон өдрийн байдлаар Банк нь нийт 68 (жаран найман) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулсан байна. Мөн 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулсан боловч гэрээ, хэлэлцээрийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй 21 (хорин нэгэн) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байна. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор дээрх сонирхлын зөрчилтэй хэлцэл хийснийг баталгаажуулсан/зөвшөөрөл олгосон байна.

Дүгнэж үзвэл тасалбар болгосон өдрийн хугацаанд ХасБанк ХК-аас нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулсан нийт 68 (жаран найман) сонирхлын зөрчилтэй хэлцлийг Банкны төлөөлөн удирдах зөвлөлөөс баталгаажуулсан/зөвшөөрөл олгосон байх тул холбогдох хуульд нийцсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Дөрөв. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан эсэх, Банк хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүрэг, тэдгээрийн эрхийг хамгаалах чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх:

Хуулийн фирмийн зүгээс ХасБанк ХК-ийн үйл ажиллагаандаа батлан мөрдүүлсэн компанийн засаглалд хамаарах 27 (хорин долоон) дүрэм, журам нь Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл ХасБанк ХК-ийн Дүрэм болон засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн засаглалын кодекст заасан шаардлагын хүрээнд батлагдаж, агуулгын хувьд Компанийн засаглалын кодекст нийцсэн, Банк нь үйл ажиллагаандаа Компанийн засаглалын кодексоор зохицуулагдсан бусад шаардлагуудыг мөрдөн ажилласан байна. Мөн Банк нь хувьцаа эзэмшигчийн өмнө хуулиар хүлээсэн үүрэг, тэдгээрийн эрхийг хамгаалах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Тав. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх болон шаардах эрх хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан эсэх асуудлаар:

ХасБанк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны [●] сарын [●]-ны өдрийн ээлжит хурлын №[●] тоот [●] тогтоол гарсан.

[Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр гарснаар энэ хэсгийн дүгнэлт бичигдэнэ.]

Зургаа. ХасБанк ХК-д нэгдэж буй хуулийн этгээд болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагаанд хийсэн дүгнэлт:

- (i) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, хүчин төгөлдөр эсэх асуудлаар:

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байх бөгөөд тус компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл нь улсын бүртгэлд бүртгэгдсэн хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

- (ii) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн зарласан болон гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион болон хувьцаанд хамаарах үнэт цаас нь хүчин төгөлдөр эсэх асуудлаар:



ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 24,685,859 (хорин дөрвөн сая зургаан зуун наян таван мянга найман зуун тавин ес) ширхэг зарласан хувьцаатай, 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 16,270,503 (арван зургаан сая хоёр зуун далан мянга таван зуун гурван) ширхэг гаргасан энгийн хувьцаатай бөгөөд үүнээс бусдаар аливаа хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргаагүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Хуулийн дүгнэлт хийж гүйцэтгэх өдрийн байдлаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас ирүүлсэн баримт материалд үндэслэн тус Компани нь аливаа хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион болон хувьцаанд хамаарах үнэт цаас гаргаагүй бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн зарласан болон гаргасан хувьцаа нь аливаа үүргийн гүйцэтгэл хангах үүрэг хүлээгээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

- (iii) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ, хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас ирүүлсэн баримт материалаас үзвэл тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 7 (долоон) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

- (iv) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Батламж гаргах тухай албан бичигт үндэслэн сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулаагүй байна гэж дүгнэлээ.

- (v) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээртэй холбоотой лицензийн гэрээ, оюуны өмчийн аливаа маргаан байгаа эсэх асуудлаар:

Хуулийн дүгнэлт үйлдэх өдрийн байдлаар ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл олгогдоогүй байх тул тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааны хүрээнд бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл байдал үүсээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр олгогдсон үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл байхгүй, ямар нэгэн лиценз, зохиогчийн эрх, патент эзэмшдэггүй, эрхийн хамгаалалт хийгдэж, бүртгэгдсэн 6 (зургаан) барааны тэмдэг хугацаа дууссан бөгөөд аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгээгүй байна гэж дүгнэлээ.

- (vi) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас гаргаж өгсөн мэдээлэл, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2025 оны 02 сарын 04-ний өдрийн №02 тоот Үнэт цаас эзэмшлийн тодорхойлолт болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас авсан мэдээлэлд үндэслэн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 1 (нэг) төрлийн 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг хувьцаа эзэмших эрх нь хүчин төгөлдөр бөгөөд үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн хэлцэл хийгдээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас ирүүлсэн мэдээлэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 02 сарын 06-ны өдрийн Эд хөрөнгө бүртгэлтэй эсэх тухай лавлагаа болон 2025 оны 02 сарын 11-ний өдрийн Аж ахуйн нэгж, байгууллагын татварын тодорхойлолтоор үл хөдлөх эд хөрөнгө өмчилдөггүй гэж дүгнэлээ.



- (vii) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хөдөлмөрийн гэрээ, ажилчдын тэтгэмжийн төлөвлөгөө, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх төлөвлөгөө, болзошгүй өр төлбөрийн бодлого нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан Үйлчилгээний гэрээ нь Иргэний хуульд, Гүйцэтгэх захирал болон няглан бодогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээ нь Хөдөлмөрийн тухай хуульд тус тус нийцсэн байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас ажилчдад хамаарах хөдөлмөрийн дотоод журам, ажилчдын тэтгэмжийн төлөвлөгөө, ажилчдад хувьцаа эзэмшүүлэх төлөвлөгөө, болзошгүй өр төлбөрийн бодлогыг Хуулийн фирмд ирүүлээгүй тул дурдсан төлөвлөгөө болон баримт бичгийг батлан мөрдүүлээгүй гэж Хуулийн фирмээс үзлээ.

- (viii) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь байгаль орчны хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2011 оны 07 сарын 20-ны өдрийн №А-30/2011 тоот тушаалаар “Нийгэм, байгаль орчны удирдлагын бодлого”-ыг өөрийн болон түүний хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагаандаа дагаж мөрдөхөөр баталсан байна.

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байгаа байгаль орчинтой холбоотой журам нь хууль тогтоомжийн хүрээнд байгаа эсэх талаар шалгасан бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг тул хуульд тусгайлан үүрэг болгосон шаардлага байхгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

- (ix) ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн даатгалын бодлого нь холбогдох хууль тогтоомжийн шаардлага хангаж байгаа эсэх асуудлаар:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь 2024 оны 05 сарын 22-ны өдөр ТэнГэр даатгал ХХК-тай байгуулсан №2024/002 дугаартай Даатгалын ерөнхий гэрээ болон тус гэрээний дэд гэрээ болох Удирдах ажилтны хариуцлагын даатгалын гэрээг тус тус байгуулсан нь тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Удирдах ажилтны хариуцлагын даатгалын дэд гэрээний хувьд 2025 оны 05 сарын 23-ны өдрийн 23 цаг 59 минут хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр хэрэгжихээр байх бөгөөд даатгалын үнэлгээний нь 10,000,000 (арван сая) ам.доллартой тэнцэхүйц төгрөг байхаар талууд харилцан тохиролцжээ.

Тус дэд гэрээнд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь даатгалын хураамж болох 60,588 (жаран мянга таван зуун наян найман) ам.доллартой тэнцэхүйц төгрөгийг 2024 оны 05 сарын 30-ны өдөрт багтаан даатгагчид төлөхөөр заасан байна.

Иймд Хуулийн фирмээс ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ТэнГэр даатгал ХХК-тай байгуулсан Удирдах ажилтны хариуцлагын даатгалын дэд гэрээнд заасан даатгалын хураамж төлөх үүргээ бүрэн биелүүлсэн гэж үзэх үндэслэлтэй гэж үзсэн бөгөөд ХасБанк ХК нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг өөртөө нэгтгэх замаар өөчлөн байгуулагдах тохиолдолд дурдсан даатгалын гэрээний хүчин төгөлдөр байдал болон хэрхэн эрх залгамжлах, дуусгавар болох, цуцлах, асуудлаар нарийвчлан судаллаа.

Энэхүү Даатгалын ерөнхий гэрээ, түүний дэд гэрээ болох Удирдах ажилтны хариуцлагын даатгалын гэрээ цуцлагдсанаар Даатгалын ерөнхий гэрээний 2 дугаар зүйлийн 2.4.2 дахь заалтад заасны дагуу даатгагч эрсдэлийг өөртөө хүлээж байсан хугацаанд ногдох хураамж болон даатгалтай холбогдон гарсан зардал, үзүүлсэн үйлчилгээний хөлсийг хасаж, хураамжийг дэд гэрээнд заасны дагуу тооцон буцаан олгох үр дагавартай байна. Харин энэхүү даатгалын ерөнхий гэрээний хугацаанд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас нөхөн төлбөр авсан тохиолдолд даатгагч гэрээний үүргээ биелүүлсэн гэж үзэн хураамжийг буцаан олгохгүй байхаар гэрээнд тусгайлан зохицуулсан байна.



Нэгтгэн дүгнэж үзвэл Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК тасалбар болгосон өдрийн байдлаар эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй бөгөөд иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй байна. Мөн энэхүү Хуулийн дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар Тэнгэр Санхүүгийн Нэгдэл нь гэмт, хэрэг зөрчилд холбогдон шалгагдаагүй байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

(xi) Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх асуудлаар:

Хуулийн фирм нь Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх болон бусдын өмнө хүлээсэн өр төлбөртэй эсэх асуудлыг нягталж харьяа төрийн эрх бүхий байгууллагаас дэлгэрэнгүй лавлагаа, тодорхойлолт гаргуулан авлаа.

Монголын татварын албаны 2025 оны 02 сарын 11-ний өдрийн №25.1003.7d68694e-5317-4104-a696-ba1a05da33a3 тоот аж ахуйн нэгж, байгууллагын цахим лавлагаа, тодорхойлолтоос үзвэл Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь 981,194.1 (есөн зуун наян нэгэн мянга нэг зуун ерэн дөрвөн төгрөг арван мөнгө) төгрөгийн өртэй бөгөөд 67,804,942.88 (жаран долоон сая найман зуун дөрвөн мянга есөн зуун дөчин хоёр төгрөг наян найман мөнгө) төгрөгийн илүү төлөлттэй буюу авлагатай болохыг тодорхойлсон байна.

Иймд дээр дурдсан төрийн эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь дээр дурдсан татварын дутуу төлөлтөөс бусдаар нийгмийн даатгал, шийдвэр гүйцэтгэх газарт төлөх өр төлбөргүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл ХасБанк ХК нь Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журамд тогтоосон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой шалгуурыг [●] байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд бүхэлд нь өгсөн үнэлэлт, дүгнэлтэд тооцогдохгүй бөгөөд зөвхөн Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг нэгтгэж ХасБанк ХК-ийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагын тавьсан шаардлагын хүрээнд буюу дээр дурдагдсан асуудлуудын хүрээнд хязгаарлагдана.

ХҮНДЭТГЭСЭН,

УДИРДАХ ПАРТНЕР  Ж.НЯМБАЯР



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 03 сарын 05 өдөр

№ R-2025-10

Улаанбаатар хот

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болон ХасБанк ХК-ийн хооронд байгуулсан
Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвлөмж хүргүүлэх тухай

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК ("ТСН") болон ХасБанк ХК ("ХасБанк")-ийн хооронд
2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан Нэгтгэх гэрээний 8 дугаар зүйлийн 8.6(b)
дахь заалтад үндэслэн, ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 03
дугаар сарын 05-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой
компани болох ТСН нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны
дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших
хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх
шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг ("**Хуулийн шаардлага**");
2. ХасБанкны хувьцаа эзэмшигчид SR-2024-09 тоот тогтоол гаргаж, энэхүү Хуулийн
шаардлагыг хангахдаа ХасБанкийг (i) Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банктай
Фреймворк гэрээ болон (ii) Олон Улсын Санхүүгийн Корпорацийтай Бодлогын гэрээг тус
тус Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд
ТСН-ийг ХасБанкинд нэгтгэж, Нэгтгэх гэрээг байгуулахаар шийдвэрлэсэн ("**Нэгтгэх
урьдчилсан нөхцөл**"), нэгдлийн үр дүнд ХасБанк үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид
ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болох нь зүйтэй гэж үзсэн болохыг ("**Нэгтгэх
хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах**");
3. ХасБанкны хувьцаа эзэмшигчид нь SR-2024-07 болон SR-2024-08 тоот тогтоолоор
Нэгтгэх урьдчилсан нөхцөлийг биелүүлэхээр шийдвэрлэсэн болохыг;
4. Нэгтгэх урьдчилсан нөхцөл хангагдаж, ТСН болон ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн
хурлаар Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсний дараа
2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр ТСН болон ХасБанкны хооронд Нэгтгэх гэрээг
байгуулж холбогдох зөвшөөрөл авахаар Монголбанкинд хүргүүлсэн болохыг;
5. Монголбанкнаас нэгтгэх өөрчлөн байгуулалтын хүсэлтийг хянах явцад ТСН-ийн нийт
гаргасан хувьцааны 20.39%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч болох МАК Инвест Кэй
Эф Ти-д бий болсон өөрчлөлт нь түүний хувьцаа эзэмшигчдийн бүтцэд Банкны тухай
хуулийн шаардлагад нийцүүлэн өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээг бий болгосон ба
МАК Инвест Кэй Эф Ти нь ТСН дэх өөрийн эзэмшлийн хувьцааг шинээр үүсгэн
байгуулагдсан, нэг эцсийн өмчлөгч хасагдсанаас бусдаар эцсийн өмчлөгчийн бүтэц
ижил төсөөтэй бие даасан компани болох МАК Инвест Эс Жи Пи Ти И Эл Ти Ди ("**МАК**")

Инвест Эс Жи")-д шилжүүлэх замаар Банкны тухай хуулийн шаардлагад нийцүүлэхээр шийдвэрлэсэн болохыг ("ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлт");

6. ТСН-ийн Хувьцаа эзэмшигчид нь ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлтөд холбогдуулан, ТСН-ийн саналын эрх бүхий хувьцааны 20.39%-ийг эзэмших шууд хувьцаа эзэмшигчээр МАК Инвест Эс Жи-г хүлээн зөвшөөрөхөөр SGR-2025-01 тоот тогтоол баталсан болохыг; мөн
7. ХасБанк болон ТСН-ийн хооронд байгуулсан Нэгтгэх гэрээнд ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлтийг тусгаж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг харгалзан, ТУЗ нь Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. ТСН болон ХасБанкны хооронд байгуулах Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг 1 дүгээр хавсралтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд батлуулахаар оруулсугай.
2. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээтэй холбогдуулан, Нэгтгэх өөрчлөн байгуулалтад шаардагдах баримт бичгийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх зорилготой "Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах нөхцөл, журам"-д оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтын дагуу баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг 1 дүгээр хавсралтын дагуу шаардлагатай бусад холбогдох баримт бичгийн хамт ХасБанкны нэрийн өмнөөс үйлдэх эрхийг ХасБанкны Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав ("Эрх бүхий этгээд")-д олгож, тийнхүү үйлдэхийг даалгасугай.


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ



ОГНОО

2025

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК


-ба-

ХАСБАНК ХК-ийн

ХООРОНД БАЙГУУЛСАН

2024 оны 5-р сарын 17-ны өдрийн Нэгтгэх
гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
гэрээ

Монгол Улс, Улаанбаатар хот



– 1 –


Энэхүү 2024 оны 5-р сарын 17-ны өдрийн Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ (цаашид **"Нэмэлт, өөрчлөлтийн гэрээ"** гэх)-г 2025 оны _____-ны өдөр (цаашид **"Хүчин төгөлдөр болох өдөр"** гэх) дараах талуудын хооронд байгуулав:

- (1) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдан, үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жамьян гүний гудамж, Олон улсын худалдааны төв, 16 давхар албан ёсны хаягт бүртгэлтэй, 2595788 регистрийн дугаартай, хязгаарлагдмал хариуцлагатай компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК (цаашид **"ТСН"** гэх); ба
- (2) Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдан, үйл ажиллагаа явуулж буй Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, ХасБанкны байр албан ёсны хаягт бүртгэлтэй, 2578697 регистрийн дугаартай, нээлттэй хувьцаат компани болох ХасБанк ХК (цаашид **"ХасБанк"** гэх)

(цаашид хамтад нь **"Талууд"**, тус тусад нь **"Тал"** гэх).

УДИРТГАЛ

- A. ХасБанк нь Банкны тухай хуулийн дагуу банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий арилжааны банк бөгөөд ТСН нь одоогийн байдлаар ХасБанкны нийт зарласан болон гаргасан хувьцааны 94.99 хувь буюу 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг ХасБанкны Хувьцааг эзэмшиж байгаа нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- B. ТСН ба ХасБанк нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг ба Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа нь тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага (цаашид **"Банкны тухай хуулийн шаардлага"** гэх)-ыг 2026 оны 12-р сарын 31-ний өдрөөс өмнө хангах шаардлагатай болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- C. Энэхүү Банкны тухай хуулийн шаардлагыг хангах үүднээс ТСН ба ХасБанк нь 2024 оны 5-р сарын 17-ны өдөр Нэгтгэх гэрээ (цаашид **"Нэгтгэх гэрээ"** гэх)-г байгуулсан бөгөөд энэхүү гэрээнд ТСН-ийн үйл ажиллагааг нэгдэж байгаа компанийн хувьд зогсоож, нэгтгэж байгаа компанийн хувьд ХасБанкны үйл ажиллагааг үргэлжлүүлэх замаар ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх, үр дүнд нь ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болохоор (цаашид **"Нэгтгэл"** гэх) заасныг **ТЭМДЭГЛЭН**;
- D. Унгар Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Будапешт 1062, Вачи ут 1-3.А.эп.6.эм албан ёсны хаягт бүртгэлтэй, 01-09-407609 регистрийн дугаартай компани болох МАК Инвест КэйЭфТи (цаашид **"МАК Инвест КэйЭфТи"** гэх) нь ТСН-ийн нийт зарласан болон гаргасан хувьцааны 20.39% буюу 3,316,985 ширхэг энгийн хувьцаа (цаашид **"МАК-ийн хувьцаа"** гэх)-г эзэмшиж байгаа ТСН-ийн хувьцаа эзэмшигч болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- E. 2024 оны 10-р сарын 31-ний өдөр МАК Инвест КэйЭфТи нь Сингапур Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Сингапур Улс, Манулайф Тауэр 048424, Кросс гудамж 8, 24-03/04 тоот албан ёсны хаягт бүртгэлтэй, 202444045G регистрийн дугаартай компани болох МАК Инвест Эс Жи Пи Ти И Эл Ти Ди (цаашид **"МАК Инвест Эс Жи"** гэх)-тэй Хувьцаа шилжүүлэх гэрээ болон Эрх шилжүүлэх гэрээг тус тус байгуулсан бөгөөд тус гэрээнүүдийн дагуу МАК Инвест КэйЭфТи нь МАК-ийн хувьцаа болон түүнд холбогдох



- 2 -

эрх, үүргийг бүхэлд нь МАК Инвест Эс Жи-д шилжүүлэхээр заасан болохыг **ТЭМДЭГЛЭН**;

- F. 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр ТСН болон МАК Инвест Эс Жи нь Гэрээнд нэгдэх гэрээ (цаашид "Гэрээнд нэгдэх гэрээ" гэх)-г байгуулсан бөгөөд энэхүү гэрээний дагуу МАК Инвест Эс Жи нь тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулсан 2013 оны 10-р сарын 1-ний өдрийн ТСН-ийн нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан 4 дэх Хувьцаа эзэмшигчдийн гэрээ (цаашид "ХЭГ" гэх)-ний нөхцөл, шаардлагыг дагаж мөрдөхөөр тохиролцсон бөгөөд МАК Инвест КэйЭфТи-гийн ХЭГ-ний дагуу хүлээсэн бүхий л эрх, үүргийг хүлээн авч, ХЭГ-ний тал болохоор тохиролцсон болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- G. Гэрээнд нэгдэх гэрээг байгуулж мөн МАК Инвест Эс Жи нь МАК Инвест КэйЭфТи-гийн оронд ТСН-ийн хувьцаа эзэмшигч болж байгаатай холбогдуулан Талууд энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээнд заасны дагуу Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтэй байгааг **ТЭМДЭГЛЭН**,

ИЙНХҮҮ дор дурдсаныг харилцан тохиролцов:

1. **НЭР ТОМЬЁО, ТАЙЛБАР**

- (a) Энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээнд:

"Нэмэлт, өөрчлөлт" гэж энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээний 2 дахь заалтад заасны дагуу хийгдсэн буюу хийгдэх нэмэлт, өөрчлөлтүүдийг хэлнэ.

- (b) Энэхүү гэрээнд өөрөөр тодорхойлоогүй бол Нэгтгэх гэрээнд тодорхойлогдсон нэр томьёо (аливаа бусад гэрээ, баримт бичгийг шууд эсхүл иш татах замаар тодорхойлсон эсэхээс үл хамааран) нь энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээнд адил утгыг илэрхийлнэ.

- (c) Нэгтгэх гэрээ болон энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээг нэг баримт бичигт тооцон ойлгож, тайлбарлана.

2. **Нэмэлт, өөрчлөлт**


Хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээний Хавсралт 1-д заасан Нэмэлт, өөрчлөлтөөр Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

3. **Хүчин төгөлдөр болох өдөр**

Энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээ нь Хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4. **ЦААШДЫН БАТАЛГАА**

Талууд энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээний дагуу хийгдсэн буюу хийгдэх Нэмэлт, өөрчлөлтийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай эсхүл шаардлагатай гэж үзсэн бүх үйлдэл, арга хэмжээг өөрсдийн зардлаар хийх бөгөөд үүнд энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээг байгуулснаар хийгдсэн буюу хийгдэх ХасБанкны үнэт цаасны бүртгэлд оруулах холбогдох өөрчлөлтүүдийн талаарх Холбогдох хуулийн дагуу компани дотооддоо гаргах



– 3 –


шаардлагатай зөвшөөрлүүдийг гаргах, СЗХ, МХБ, ҮЦТХТ, Монголбанк болон бусад аливаа холбогдох Төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, мэдэгдэх зэрэг хамаарна.

5. Зохицуулах хууль, маргааны харьяалал, англи хэл

Нэгтгэх гэрээний 8.4, 8.5, 8.8 дахь заалтууд энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээнд бүхэлдээ орсон мэт үйлчилнэ.

6. Бусад заалт

- (a) Энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээ болон энд иш татсан баримт бичгүүдэд энд заасан асуудалтай холбоотой Талуудын бүхий л үүргүүдийг тусгасан бөгөөд энд заасан асуудалтай холбоотой өмнө нь илэрхийлсэн аливаа ойлголцоо, тохиролцоог хүчингүйд тооцно.
- (b) Энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээнд зөвхөн Талуудын зохих ёсоор бичгээр үйлдсэн баримт бичгийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулна.
- (c) Энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээг хэд хэдэн хувь үйлдэж болох бөгөөд тэдгээр нь бүгд эх хувьд тооцогдох хэдий ч бүх хувиуд нь нэг адил гэрээ болно.
- (d) Энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээний дагуу нэмэлт, өөрчлөлт орсноос бусад Нэгтгэх гэрээний бүхий л зүйл, заалтууд нь өөрчлөгдөхгүй бөгөөд бүрэн хүчин төгөлдөр, хүчинтэй хэвээр байна.



– 4 –

ХАВСРАЛТ 1

НЭГТГЭХ ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэгтгэх гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулна:

- (1) Нэгтгэх гэрээний Удиртгалын В хэсэгт заасан “2023 оны 12 дугаар сарын 31” гэснийг “2026 оны 12 дугаар сарын 31” гэж өөрчилнө;
- (2) Нэгтгэх гэрээний 3.4-р заалтад заасан “МАК Инвест КэйЭфТи” гэснийг “МАК Инвест Эс Жи” гэж өөрчилнө;
- (3) Нэгтгэх гэрээний Хавсралт 3 (ХасБанкны нэгтгэлтийн дараах нэгдсэн тайлан баланс)-ыг бүхэлд нь устгаж, дараахаар өөрчилнө:

[****]¹

¹ 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн аудитлагдсан тайлан дээр үндэслэсэн нэгдсэн тайлан баланс

Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

... тоот гэрээний Хавсралт 3

ХАСБАНК ХК САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
/Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанк ХК-д нэгтгэсний дараах/

2024 оны Арван хоёрдугаар сар 31

(Төгрөгөөр)

	Балансын зүйл	ХасБанк ХК 2024/12/31	Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК Нэгтгэх баланс 2024/12/31	Нэгтгэх бичилт 2024/12/31	ХасБанк ХК Нэгтгэсний дараах 2024/12/31
1	ХӨРӨНГӨ				
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,895,273,697,466.20		-	1,895,273,697,466.20
1.1.1	Бэлэн мөнгө	33,011,522,688.03			33,011,522,688.03
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	773,667,632,339.11			773,667,632,339.11
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1,085,262,868,849.46			1,085,262,868,849.46
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,331,673,589.60			3,331,673,589.60
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	397,890,873,112.18		-	397,890,873,112.18
1.2.1	Монголбанкнд байршуулсан хөрөнгө	398,103,270,284.07			398,103,270,284.07
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-			-
1.2.3	Бусад хөрөнгө	-			-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-			-
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(212,397,171.89)			(212,397,171.89)
1.3	Хөрөнгө оруулалт	164,840,923,389.61	101,817,773,344.70	(101,817,773,344.70)	164,840,923,389.61
1.3.1	Арилжааны үнэт цаас	-			-
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	110,519,731,431.07			110,519,731,431.07
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	40,000,000,000.00			40,000,000,000.00
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-			-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	101,817,773,344.70	(101,817,773,344.70)	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	9,000,000,000.00			9,000,000,000.00
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	7,014,934,028.89			7,014,934,028.89
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	(1,693,742,070.35)			(1,693,742,070.35)
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	3,682,590,671,960.92		-	3,682,590,671,960.92
1.4.1	Хэвийн зээл	3,555,205,923,094.54			3,555,205,923,094.54
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	67,879,360,313.83			67,879,360,313.83
1.4.3	Хэвийн бус зээл	14,110,460,955.16			14,110,460,955.16
1.4.4	Эргэлзээтэй зээл	12,813,432,207.54			12,813,432,207.54
1.4.5	Муу зээл	47,383,379,858.50			47,383,379,858.50
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(18,472,474,486.19)			(18,472,474,486.19)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	62,436,985,777.13			62,436,985,777.13
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(58,766,395,759.58)			(58,766,395,759.58)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	10,050,723,082.09			10,050,723,082.09
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	15,847,030,662.03		-	15,847,030,662.03
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	15,847,030,662.03			15,847,030,662.03
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	-			-
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-			-
1.6.4	Бусад	-			-
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	66,304,075,963.19	-	-	66,304,075,963.19
1.7.1	Бусад тооцоо	38,137,976,591.44			38,137,976,591.44
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	2,913,396,664.02			2,913,396,664.02
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	724,526,844.53			724,526,844.53
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	3,901,079,873.91			3,901,079,873.91
1.7.5	Татварын авлага	49,774,584.08			49,774,584.08
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	11,942,798,351.54			11,942,798,351.54
1.7.7	Бусад	8,634,523,053.68			8,634,523,053.68
1.8	Үндсэн хөрөнгө	71,071,813,851.88		-	71,071,813,851.88
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-		-	-
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	1,089,948,722.66		-	1,089,948,722.66
1.11	Бнэт бус хөрөнгө	16,833,960,840.69		-	16,833,960,840.69
	Нийт хөрөнгийн дүн	6,321,793,719,051.46	101,817,773,344.70	(101,817,773,344.70)	6,321,793,719,051.46
2	ӨРТӨЛБӨР				
2.1	Харилцах	817,461,963,217.99		-	817,461,963,217.99
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	817,461,963,217.99			817,461,963,217.99
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	-			-
2.2	Хадгаламж	2,535,432,581,681.66		-	2,535,432,581,681.66
2.2.1	Хугацаагүй хадгаламж	200,924,056,034.28			200,924,056,034.28
2.2.2	Хугацаатай хадгаламж	2,305,572,882,340.47			2,305,572,882,340.47
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	13,361,723,903.61			13,361,723,903.61
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	15,573,919,403.30			15,573,919,403.30
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,036,158,841,263.56		-	2,036,158,841,263.56

Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	332,372,220,873.02			332,372,220,873.02
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	1,688,771,138,578.17			1,688,771,138,578.17
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(11,196,777,411.89)			(11,196,777,411.89)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	26,212,259,224.26			26,212,259,224.26
2.4	Бусад эх үүсвэр	40,229,669,289.86		-	40,229,669,289.86
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	-			-
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	-			-
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	14,996,157,806.96			14,996,157,806.96
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (repo)	8,880,066,833.29			8,880,066,833.29
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	406,139,892.73			406,139,892.73
2.4.6	Бусад	15,303,350,706.88			15,303,350,706.88
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-			-
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	643,954,050.00			643,954,050.00
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	9,542,836,602.61			9,542,836,602.61
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	68,812,286,617.39			68,812,286,617.39
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	82,552,785,616.99			82,552,785,616.99
2.8	Хоёрдогч өглөг	-			-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-		-	-
	Нийт өр төлбөрийн дүн	5,590,190,964,290.06		-	5,590,190,964,290.06
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ				
3.1	Хувь ийнлүүлсэн хөрөнгө	105,270,000,000.00	16,270,503,000.00	(16,270,503,000.00)	105,270,000,000.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-			-
3.1.2	Энгийн хувьцаа	105,270,000,000.00	16,270,503,000.00	(16,270,503,000.00)	105,270,000,000.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	30,388,870,985.26	85,547,270,344.70	(85,547,270,344.70)	30,388,870,985.26
3.3	Халаасны хувьцаа	(29,667,800.00)	-		(29,667,800.00)
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	18,352,368,952.90	-		18,352,368,952.90
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	515,406,908,425.24	-		515,406,908,425.24
3.6	Бусад өөрийн хөрөнгө	62,214,274,198.01	-	-	62,214,274,198.01
3.6.1	Хувьцааны опцион	-	-		-
3.6.2	Ноогийн сан	11,439,407,367.49	-		11,439,407,367.49
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	-	-		-
3.6.4	Эрдэлийн сангийн нөөц	48,433,631,666.99	-		48,433,631,666.99
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-		-
3.6.6	Хөрвөх өр төлбөр	-	-		-
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	-	-		-
3.6.8	Бусад	2,341,235,163.53	-		2,341,235,163.53
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	731,602,754,761.41	101,817,773,344.70	(101,817,773,344.70)	731,602,754,761.41
	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	6,321,793,719,051.46	101,817,773,344.70	(101,817,773,344.70)	6,321,793,719,051.46


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г ЦЭВЭГЖАВ

Г ЭРДЭНЭБАЯР



– 5 –

ДЭЭР ДУРДСАНЫГ НОТЛОН энэхүү Нэмэлт, өөрчлөлтийн гэрээг Талууд зохих ёсоор байгуулсан бөгөөд Нэмэлт, өөрчлөлтийн гэрээний эхэнд заасан өдөр хүчин төгөлдөр болно.

ХасБанк ХК-ийг төлөөлж, түүний нэрийн өмнөөс


Нэр: Г.ЦЭВЭГЖАВ
Албан тушаал: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг төлөөлж, түүний нэрийн өмнөөс

Нэр: Н.ОТГОНЧУЛУУН
Албан тушаал: НЯГТЛАН БОДОГЧ

БОЛОН

Нэр: [нэрийг оруулах]
Албан тушаал: [албан тушаалыг оруулах]



Хавсралт 2


“Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах: Нөхцөл, журам”-д оруулах нэмэлт, өөрчлөлт

1. Удиртгал

- 1.1 Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК (цаашид “ТСН” гэх) ба ХасБанк ХК (цаашид “ХасБанк” гэх) (цаашид хамтад нь “Талууд” гэх)-ийн хооронд 2024 оны 5-р сарын 17-ны өдөр байгуулсан Нэгтгэх Гэрээ, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт (цаашид “Нэгтгэх гэрээ” гэх)-ийн дагуу Талуудыг нэгтгэх (цаашид “Нэгтгэл” гэх) үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгүүдийн хүрээнд, мөн Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “СЗХ” гэх) болон Монголын Хөрөнгийн Бирж (цаашид “МХБ” гэх)-ид албан ёсоор хүргүүлэх зорилгоор Талууд “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах: нөхцөл, шаардлага” гэх баримт бичгийг бэлтгэсэн бөгөөд СЗХ, МХБ-ид 2024 оны 6-р сард хүргүүлсэн болно (цаашид “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах: нөхцөл, шаардлага” гэх).
- 1.2 Нэгтгэлийн тодорхой нөхцөл, шаардлагуудыг тусгасан “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах: нөхцөл, шаардлага”-ыг ТСН-ийн 2024 оны 2-р сарын 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын SGR-2024-03 дугаартай тогтоол болон ХасБанкны 2024 оны 4-р сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын SR-2024-09 дугаартай тогтоолоор тус тус баталсан болно.
- 1.3 2024 оны 10-р сарын 31-ний өдөр ТСН-ийн хувьцаа эзэмшигч болох МАК Инвест КэйЭфТи (компанийн бүртгэлийн дугаар: 01-09-407609) нь МАК Инвест Эс Жи Пи Ти И Эл Ти Ди (компанийн бүртгэлийн дугаар: 202444045G) (цаашид “МАК Инвест Эс Жи” гэх)-тэй Хувьцаа шилжүүлэх гэрээ болон Эрх шилжүүлэх гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээнүүдийн дагуу МАК Инвест КэйЭфТи нь ТСН-д эзэмшиж байсан бүх энгийн хувьцаагаа МАК Инвест Эс Жи-д холбогдох бүх эрх, үүрэгтэй нь хамт шилжүүлсэн болно (цаашид “ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт” гэх).
- 1.4 ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт зэргийг оролцуулан өөр бусад өөрчлөлтүүдийг тусгахаар Нэгтгэх гэрээний тодорхой заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа болно (цаашид “Нэгтгэх гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт” гэх).
- 1.5 ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт болон Нэгтгэх гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах: нөхцөл, шаардлага”-д доорх 2.1 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулна.

2. Нэмэлт, өөрчлөлт

- 2.1 “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах: нөхцөл, шаардлага”-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулна:
 - (а) 1.1 дэх заалт (Ерөнхий зүйл) дахь “...Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК ба ХасБанк ХК (цаашид хамтад нь “Талууд” гэх)-ийн хооронд байгуулсан Нэгтгэх Гэрээ” гэсний араас “болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн...” гэж нэмнэ;
 - (б) 4.3 дахь заалт дахь “МАК Инвест КэйЭфТи” гэснийг “МАК Инвест Эс Жи” болгон өөрчилнө.



- 2.2 “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах: нөхцөл, шаардлага”-д тусгасан, энэхүү баримт бичгийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулснаас бусад Нэгтгэлийн нөхцөл, шаардлага нь өөрчлөгдөхгүй хэвээр үлдэнэ.

3. **Бусад зүйл**

Нэгтгэх Гэрээний бүх заалтуудыг энэхүү баримт бичигт шууд тусгагдсан эсэхээс үл хамааран энэхүү баримт бичгийн салшгүй хэсэг гэж үзнэ. Энэхүү Нөхцөлийг уншиж, тайлбарлахдаа Нэгтгэх Гэрээний бүх заалтыг хамааруулах бөгөөд тэдгээрийг энэхүү баримт бичиг дээр бүрэн тусгагдсан мэт хүчин төгөлдөр гэж үзнэ.



Хурлаар шийдвэрлэх зургаадугаар асуудал:

ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай

ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ

ХасБанкны Дүрмийн 8.6(v) дахь заалтад зааснаар ТУЗ-ийн төсвийг хувьцаа эзэмшигчид баталдаг. Иймд хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр ХасБанкны ТУЗ-өөс 2025 оны төсвийг 7,250 сая төгрөгийн дүнтэйгээр оруулж байна.

ТУЗ-ийн төсөв 2024 онд 6,773 сая төгрөгөөр батлагдаж байсан бөгөөд бодит гүйцэтгэл 6,704 сая төгрөг байв.

ТУЗ-ийн төсөв нь (i) хөлс, нэмэгдэл, урамшуулал (үүнд ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн хөлс, нэмэгдэл, урамшуулал багтах ба гүйцэтгэх захирал ТУЗ-ийн гишүүнээр ажилласныхаа төлөө аливаа, хөлс, нэмэгдэл, урамшуулал авдаггүй), (ii) бусад зардал (татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, зорчих болон буудаллах зардал, хурал зохион байгуулах зардал, ТУЗ-д үйлчилгээ үзүүлэх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын үйлчилгээний төлбөр зэрэг) багтана.

	2024 оны төсөв	2024 оны гүйцэтгэл	2025 оны төсөв
(Сая төгрөгөөр)	6,773.5	6,704.6	7,250.8

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 25 оны 03 сарын 05 өдөр

№ R-2025-07

Улаанбаатар хот

ХасБанкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны
төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар
батлуулахаар санал болгох тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.4 болон 8.6 (v) дэх хэсгийг тус тус үндэслэн
Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн
ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо ("ЗНДЦУХ")
2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хурлаараа хэлэлцээд Банкны ТУЗ-ийн 2025
оны санхүүгийн жилийн төсөв ("ТУЗ-ийн 2025 оны төсөв")-ийг хавсралтад заасны дагуу
санал болгосныг; мөн
2. ТУЗ нь ЗНДЦУХ-ноос санал болгосны дагуу ТУЗ-ийн 2025 оны төсвийг Банкны Хувьцаа
эзэмшигчдийн хуралд оруулж батлуулахыг дэмжсэн болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн 2025 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралт ёсоор Банкны Хувьцаа
эзэмшигчдэд санал болгон танилцуулж, батлуулахыг дэмжсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
03 дугаар сарын 05-ны өдрийн Р-2025-07 дугаар тогтоолын Хавсралт



**ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2025 ОНЫ ТӨСӨВ**
(Банкны Хувьцаа эзэмшигчдээр батлуулах)

Д	Зориулалт	Дүн төгрөгөөр (сая)
1	Хөлс ¹	5,523.00
2	Бусад зардал	1,727.8
	Нийт дүн	7,250.8

-оОо-

¹ Хөлс гэдэгт хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор баталсан ТУЗ-ийн гишүүдийн хөлс, нэмэгдэл, мөн ТУЗ-ийн даргатай байгуулан хүчин төгөлдөр хөлсөөр ажиллах гэрээний нөхцөлд заасан ТУЗ-ийн даргын хөлс, урамшууллыг ойлгоно.



Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл]-1

2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК (**"Банк"**)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтын дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (**"ТУЗ"**) 2024 оны үйл ажиллагааны тайлан (**"2024 оны үйл ажиллагааны тайлан"**)-г хянан хэлэлцээд 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-09 тоот тогтоол гарган, 2024 оны үйл ажиллагааны тайлан нь Банкны үйл ажиллагааны үр дүнг бодитоор ил тод илэрхийлсэн гэж дүгнэж (**"ТУЗ-ийн дүгнэлт"**), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны 2024 оны үйл ажиллагааны тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл]-2

2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн
талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн, ХасБанк ХК (**"Банк"**)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-ийн зөрчилгүй гэж нягтлан баталгаажуулсан Банкны 2024 оны санхүүгийн тайлан (**"2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан"**)-г Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (**"ТУЗ"**) хянан хэлэлцээд, тус тайлан нь Банкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу бодитоор, ил тод тайлагнасан гэж 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн R-2025-17 дугаар тогтоолоороо дүгнэн (**"ТУЗ-ийн дүгнэлт"**), Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг; мөн
2. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчид хэлэлцэн батлах бүрэн эрхтэй болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Банкны 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг энэхүү тогтоолын хавсралт ёсоор дээрх ТУЗ-ийн дүгнэлтийн хамт баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

Банкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК (**"Банк"**)-ийн Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Ногдол ашиг хуваарилах эсэх нь Банкны Дүрэмд заасан стратегийн асуудал тул Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал эцэслэн батлах шаардлагатай болохыг;
2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (**"ТУЗ"**) нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан, Банкны 2024 оны цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах (**"Жилийн эцсийн ногдол ашиг"**)-ыг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн R-2025-03 дугаар тогтоолоороо Хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;
3. ТУЗ нь 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн R-2025-17 дугаар тогтоолоор 2024 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг баталсан бөгөөд тус тайлан аливаа материаллаг өөрчлөлтгүйгээр батлагдсан болохыг; мөн
4. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6.(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Жилийн эцсийн ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Ногдол ашигт нэгж хувьцаанд 27.00 (хорин долоо) төгрөг зарлан хуваарилсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийг Жилийн эцсийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү шийдвэр батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногоос хэтрүүлэлгүйгээр Жилийн эцсийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь банкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- 1. Санхүүгийн Зохицуулах Хороо (“СЗХ”) нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахдаа Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5 болон 81.6 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн нэр дэвшүүлэх чиг үүргийг цалин урамшууллын чиг үүргээс тусгаарлах зөвлөмжийг ирүүлсэн болохыг;
- 2. Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог: (а) ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, залгамж халааг төлөвлөн зохион байгуулах чиг үүрэг бүхий Нэр дэвшүүлэх хороо болон (б) компанийн засаглалын бодлого журам, ТУЗ-ийн бүтэц, цалин хөлсний бодлого, урамшууллын бүтцийг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулах асуудлыг тусгаж Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг R-2025-08 тоот тогтоолоороо зөвлөмж болгосныг; мөн
- 3. ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу, Хувьцаа эзэмшигчид Банкны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- 1. Дээр дурдсаныг үндэслэн, Банкны Дүрмийн дараах хэсгүүдэд доорх нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.	8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос <u>Нэр дэвшүүлэх хорооноос тус</u> бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.	8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.
8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.	8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын, болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хөрөөны <u>Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны</u> гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.	8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, Нэр дэвшүүлэх болон <u>Засаглал</u> , цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.

- Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанк болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт Банкны нэрийн өмнөөс холбогдох аливаа баримт бичгийн хамт хүргүүлж, бүртгүүлэхийг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банк нь Ахмад настны тухай хууль (2017)-ийн дагуу Банкнаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настанд дэмжлэг, тусламж үзүүлэх зорилгоор байгуулсан Ахмадын сантай болохыг;
2. Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр компаниудад өөрийн дүрэмдээ Ахмадын сан байгуулах болон түүнд компанийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувь (3%)-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх асуудлыг тус тус тусгайлан тусгахыг үүрэг болгосныг; мөн
3. Хувьцаа эзэмшигчид нь Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн R-2025-11 тоот тогтоолоор зөвлөмж болгосны дагуу, Банкны Дүрэмд Ахмадын сангийн зохицуулалтыг тусгах, хууль тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэх зорилгоор нэмэлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Дээрхийг үндэслэн, Банкны Дүрэмд дараах агуулга бүхий 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг нэмсүгэй:

Нэмэх заалт

5.5. Банк нь Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан Ахмадын сантай байх ба санг Банкны ахмадын тооноос хамааран Банкны цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ.

2. Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт дээр дурдсан Дүрмийн нэмэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанк болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт Банкны нэрийн өмнөөс холбогдох аливаа баримт бичгийн хамт хүргүүлж, бүртгүүлэхийг даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болон ХасБанк ХК-ийн хооронд байгуулсан
Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (**"ТСН"**) болон ХасБанк ХК (**"ХасБанк"**)-ийн хооронд 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан Нэгтгэх гэрээний 8 дугаар зүйлийн 8.6(b) дахь заалтад үндэслэн, ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой компани болох ТСН нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг (**"Хуулийн шаардлага"**);
2. ХасБанкны хувьцаа эзэмшигчид SR-2024-09 тоот тогтоол гаргаж, энэхүү Хуулийн шаардлагыг хангахдаа ХасБанкийг (i) Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банктай Фреймворк гэрээ болон (ii) Олон Улсын Санхүүгийн Корпорацитай Бодлогын гэрээг тус тус Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд ТСН-ийг ХасБанкинд нэгтгэж, Нэгтгэх гэрээг байгуулахаар шийдвэрлэсэн (**"Нэгтгэх урьдчилсан нөхцөл"**), нэгдлийн үр дүнд ХасБанк үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болох нь зүйтэй гэж үзсэн болохыг (**"Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах"**);
3. ХасБанкны хувьцаа эзэмшигчид нь SR-2024-07 болон SR-2024-08 тоот тогтоолоор Нэгтгэх урьдчилсан нөхцөлийг биелүүлэхээр шийдвэрлэсэн болохыг;
4. Нэгтгэх урьдчилсан нөхцөл хангагдаж, ТСН болон ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсний дараа 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр ТСН болон ХасБанкны хооронд Нэгтгэх гэрээг байгуулж холбогдох зөвшөөрөл авахаар Монголбанкинд хүргүүлсэн болохыг;
5. Монголбанкнаас нэгтгэх өөрчлөн байгуулалтын хүсэлтийг хянах явцад ТСН-ийн нийт гаргасан хувьцааны 20.39%-ийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч болох МАК Инвест Кэй Эф Ти-д бий болсон өөрчлөлт нь түүний хувьцаа эзэмшигчдийн бүтцэд Банкны тухай хуулийн шаардлагад нийцүүлэн өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээг бий болгосон ба МАК Инвест Кэй Эф Ти нь ТСН дэх өөрийн эзэмшлийн хувьцааг шинээр үүсгэн байгуулагдсан, нэг эцсийн өмчлөгч хасагдсанаас бусдаар эцсийн өмчлөгчийн бүтэц ижил төсөөтэй бие даасан компани болох МАК Инвест Эс Жи Пи Ти И Эл Ти Ди (**"МАК Инвест Эс Жи"**)-д шилжүүлэх замаар Банкны тухай хуулийн шаардлагад нийцүүлэхээр шийдвэрлэсэн болохыг (**"ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлт"**);
6. ТСН-ийн Хувьцаа эзэмшигчид нь ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлтөд холбогдуулан, ТСН-ийн саналын эрх бүхий хувьцааны 20.39%-ийг эзэмших шууд хувьцаа эзэмшигчээр МАК Инвест Эс Жи-г хүлээн зөвшөөрөхөөр SGR-2025-01 тоот тогтоолоор баталсан болохыг; мөн

7. ХасБанк болон ТСН-ийн хооронд байгуулсан Нэгтгэх гэрээнд ТСН-ийн хувьцаа эзэмшигчийн бүтцийн өөрчлөлтийг тусгаж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг харгалзан, Хувьцаа эзэмшигчид нь Төлөөлөн удирдах зөвлөлийн R-2025-10 тоот тогтоолоор зөвлөмж болгосны дагуу Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. ТСН болон ХасБанкны хооронд байгуулах Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг 1 дүгээр хавсралтад хавсаргасан байдлаар баталсугай.
2. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээтэй холбогдуулан, Нэгтгэх өөрчлөн байгуулалтад шаардагдах баримт бичгийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх зорилготой “Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах нөхцөл, журам”-д оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтад хавсаргасан байдлаар баталсугай.
3. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг 1 дүгээр хавсралтын дагуу шаардлагатай бусад холбогдох баримт бичгийн хамт ХасБанкны нэрийн өмнөөс үйлдэх эрхийг ХасБанкны Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав (“**Эрх бүхий этгээд**”)-д олгож, тийнхүү үйлдэхийг даалгасугай.
4. Нэгтгэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг үйлдсэний дараа энэхүү гэрээ болон түүнд холбогдох бүхий л баримт бичгийг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад эрх бүхий байгууллагад холбогдох хууль, тогтоомжийн дагуу ХасБанкны нэрийн өмнөөс хүргүүлж, бүртгүүлэхийг Өөрчлөн байгуулах комиссын гишүүдэд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл]-6

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, ХасБанк ХК (**"Банк"**)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 8.6(v) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (**"ТУЗ"**) 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-07 дугаар тогтоолоороо ТУЗ-ийн 2025 оны төсөв (**"ТУЗ-ийн 2025 оны төсөв"**)-ийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар мэдүүлсэн болохыг дурдав.

ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн 2025 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

**ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2025 ОНЫ ТӨСӨВ**

Д	Зориулалт	Дүн төгрөгөөр (сая)
1	Хөлс ¹	5,523.00
2	Бусад зардал	1,727.8
	Нийт дүн	7,250.8

-оОо-

¹ Хөлс гэдэгт хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор баталсан ТУЗ-ийн гишүүдийн хөлс, нэмэгдэл, мөн ТУЗ-ийн даргатай байгуулсан хүчин төгөлдөр хөлсөөр ажиллах гэрээний нөхцөлд заасан ТУЗ-ийн даргын хөлс, урамшууллыг ойлгоно.

ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
03 сарын 17-ны өдрийн R-2025-18 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

Комиссын дарга:	Б.Ананд, Партнер, Кэй И Партнерс ХХН
Комиссын гишүүд:	Т.Отгон, Хуульч, Кэй И Партнерс ХХН
	Г.Хажидмаа, Эрх зүйч, Кэй И Партнерс ХХН

ХАСБАНКНЫ Төлөөлөн удирдсан
7-ны өдрийн R-2025-18 дугаар
ХАСБАНК
11111111111111111111

Компанийн нэр: ХасБанк ХК

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	ХасБанкны 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	☐	☐	☐
2.	ХасБанкны 2024 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	☐	☐	☐
3.	ХасБанкны 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах	☐	☐	☐
4.a	ХасБанкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах: - Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог Нэр дэвшүүлэх хороо болон Засаглал, цалин урамшууллын хороо болгон өөрчлөн байгуулах	☐	☐	☐
4.b	ХасБанкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах: - Ахмадын сангийн зохицуулалт нэмж тусгах	☐	☐	☐
5	Нэгтгэх гэрээ болон Нэгтгэх нөхцөл, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах	☐	☐	☐
6.	ТУЗ-ийн 2025 оны төсөв	☐	☐	☐

*Цаг хугацааны бололцоог харгалзан, хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн зарим асуулт, саналыг ээлжит хурлын үеэр танилцуулж, хариулт өгч болно. Ийнхүү хэлэлцэх нь урьдчилан ирүүлсэн саналд гагцхүү хамаарахыг анхаарна уу. Хуралд биечлэн оролцож буй хувьцаа эзэмшигчид нь хурлын үеэр асуултаа шууд тавих боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: _____ / _____

Бүртгэсэн (үнэт цаасны компани) _____

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал:

_____ / _____

2025 оны ... сарын ...-ны өдөр

Тайлбар/Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү. Таны санал шийдвэрлэх асуудал бүрээр бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор үржигдэж тооцогдоно.
2. Та саналаа урьдчилан заасан хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот болон орон нутаг дахь ХасБанкны салбар, тооцооны төвүүдээр дамжуулан цаасан хэлбэрээр, эсхүл цахим хэлбэрээр өгөх боломжтой.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд санал хүчинтэйд тооцогдоно.
4. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол санал хүчингүйд тооцогдоно.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: _____

